Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ /2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

| Зорилт, арга хэмжээ | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2024 он: Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2024 он: Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь: ЗДТГ | Хэрэгжилтийн хувь: ИТХ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 8 | |
| **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | | | |
| **1.1.ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ** | | | | | | | | | |
| Зорилт 1. Эх хэл, соёл, ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэн хөгжүүлж, түүх, соёлын өвөө хамгаалан, үндэсний бахархлаа түгээн дэлгэрүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар, | 1 | Уламжлалт монгол ахуй, өв соёлоо сэргээж, монгол бичгийн бүх нийтийн хэрэглээг нэмэгдүүлэн, иргэдэд угийн бичиг хөтлүүлэх замаар монгол хүний удмын санг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2023-2024 | Соёлын төв | | 70 | Тус ажлын хүрээнд монгол бичгийн булан байгуулсан. Үндэсний бичгийн хэрэглээг сайжруулах зорилгоор хэрэглэгдэхүүнийг хийж байрлуулж ажилласан. Өвөрхангай аймгийн Соёл урлаг аялал жуулчлал залуучуудын газраас зохион байгуулсан бүтээлч сар аяны хүрээнд Монгол уламжлал шагайн наадгайг 2 төрлөөр 5 ангийн 132 сурагчдын дунд тэмцээнийг зохион байгуулсан. Насан туршийн боловсролын арга зүйч, Нийгмийн бодлогын мэргэжилтэнтэй хамтран угийн бичгийг хөтлүүлэх сургалтыг төрийн албан хаагчдад зохион байгуулж ажилласан. | 70 | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хүртээмжийг нэмэгдүүлнэ | 2 | “Цахим соёл”, “Соёлын өв-Хөгжлийн дархлаа”, “Бүх нийтийн соёлын боловсрол” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, орон нутгийн соёл, урлагийн үйлчилгээнд иргэдийн оролцоо, цахим орчин дахь үндэсний соёлын нөлөөг нэмэгдүүлнэ. | 2020-2024 | Соёлын төв | 7,0 | 70 | Тарагт Соёлын төвийн номын сангийн пэйж хуудсаар дамжуулан уншигчдад ном унших ач тус номтой холбоотой мэдээ мэдээллийг түгээж ажиллаж байна. Тарагт соёлын төв цахим хаягаараа дамжуулан зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, тэмдэглэлт баяр хийх үйл ажиллагааг иргэд олон нийтэд мэдээллэж ажиллаж байна. Өвөрхангай аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас зохион байгуулдаг соёлын бүтээл сар, нэг ном эрхэм үйлс, бүтээлч уншлага зэрэг газраас зохион байгуулж буй бүтээлч ажлуудыг тухай бүр нь бүтээлчээр хийж гүйцэтгэж ажиллаж байна. | 70 | 70 |
| | 3 | Соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулж, Эрдэнэзуу, Шанхын хийдийг улсын хамгаалалтад авах ажлыг судалж шийдвэрлэнэ. | 2020-2024 | Соёлын төв | 2,2 | 90 | ЕБС-ын бага ангийн 98 сурагчийг түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудаар явган аялал зохион байгуулж, төрж өссөн газар нутгийнхаа тухай домог хууч яриаг хүүрнэж ярьж өгч түгээн дэлгэрүүлсэн. Сумын цагдаа, ИТХ-тай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг зохион байгуулж соёлын өв хамгаалагч нартай гурвалсан гэрээг байгуулж жил бүр зохих журмын дагуу олговрыг олгож ажиллаж байна. Биет бус өвийг өвлөн уламжлуулах шавь сургалтыг бий болгохоор Монголын уламжлалт хэл хуурын анхдугаар чуулга уулзалтад Соёлын төвийн хөгжмийн багш, өвийн ажилтан нар оролцож, туршлага хуваалцаж ирсэн. Хоёрдахь уулзалт зөвлөгөөнөөр хамтарч ажиллахаар хэл хуурийг заалгах болсон. Мөн үндэсний баяр наадамд хамт бэлтгэгдэн хэл хуурыг тоглож нээлтэнд соёлыг түгээж оролцсон. Гуравдахь үйл ажиллагааг сумандаа зохион байгуулж, сурагчид иргэдэд таниулан сурталчилсан. Хэл хуурыг нээлтийг зохион байгуулан сурталчилан таниулсан. Дөрөвдэхь уулзалтыг мөн сумандаа зохион байгуулж Хэл хуурын салбар зөвлөлтэй болж танхим бий болгож. 5-н ширхэг хэл хуурийг авч, шавь сургалтыг бий болгон 70 сурагчтай хичээллэж байна.<br>Монголын уламжлалт хил хуурчдын холбооноос зохион байгуулсан хэл хуурчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлж Монголын үндэсний телевиз бусад сайтаар дамжуулан сурталчилан түгээн дэлгэрүүлж байна. | 90 | 90 |
| | 4 | Өвөрхангайн бахархал, үнэт зүйлийг цахим орчинд контент энтертаймент хэлбэрээр сурталчлах | 2020-2024 | Соёлын төв | 7 | - | Байхгүй болно. | - | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уран бүтээлийн нэгдлийг бий болгон хөгжүүлнэ. | | | | | | | |
| | 5 | Биет бус өвийг өвлөн уламжлуулах шавь сургалтыг хөгжүүлж, шилдэг өвлөн уламжлагчдыг дэмжин, төв халхын болон нутгийн онцлогтой өвийг хамгаалж, “Соёлын өв-хөгжлийн дархлаа” форумоос гаргасан “Арвайхээрийн тунхаглал”-ыг хэрэгжүүлнэ. | 2020-2024 | Соёлын төв | 8 | 50 | Биет өвийн хадгалах хамгаалах зорилгоор соёлын биет бус өвлөн уламжлагчдын судалгааг баяжуулж шинээр 5 өвлөн уламжлагчдын бүртгэлийг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Өвөрхангай аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуулуучын газраас зохион байгуулсан биет бус өвийг өвлөн уламжлагч нарын сургалт зөвлөгөөнд 5 гишүүн оролцож туршлага судлан өөр өөрсдийн онцлог өв уламжлалаа түгээн дэлгэрүүлж ажилласан. Мөн Соёлын төвийн хөгжмийн багш, соёлын өвийн ажилтан нар Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан МУХХХ-ны анхдугаар чуулга уулзалтад оролцож уг уулзалтаар дамжуулан сумандаа хэл хуурын салбар хороо байгуулж шавь сургалтыг бий болгон хөгжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүний мөрөөр Соёлын төвдөө хэл хуурын танхим байгуулж 5 ширхэг хэл хуур авч баяжилт хийн шавь сургалтаар 70 сурагчдад хичээллэж байна. | 50 | 70 |
| Зорилт 2. Соёл, урлагийн байгууллагын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг дэмжих замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг өргөжүүлэн, мэргэжлийн хүний нөөцөөр хангана. | 1 | Соёл, урлагийн нэгдсэн арга хэмжээ, уралдаан, наадам зохион байгуулан, хүүхэд залуучууд, ардын авьяастнуудын авьяас билгийг нээн хөгжүүлж, түгээн дэлгэрүүлнэ. | 2020-2024 | Соёлын төв | 3 | 70 | Соёлын төв нь тэмдэглэлт баяр бусад арга хэмжээг хамтран зохион байгуулж ажилласан. Сумын 100 жилд зориулсан нэгдсэн арга хэмжээг урлаг соёл, спортын арга хэмжээг 2 өдөр зохион байгуулж нийт 6-н багийн малчин залуус оролцож, 500 үзэгч үзсэн. Сумын бүжиг Тарагт зөв цаг бүжгийн клубын үйл ажиллагааг тогтмол явуулж 65 гишүүнтэй ажиллаж байна. Сумын 100 жилийн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж 1200 үзэгч үзсэн. Өвөрхангай аймгийн баруун бүсийн сумдын туршлага судлах урлаг соёлын нэгдсэн бага наадамд байгууллага хамт олноороо оролцож Тэргүүн байр эзэлсэн. Өвөрхангай аймгийн наадамд 30-н сурагчийг бэлтгэн хамруулж нээлтэнд оролцуулсан. ЕБС-ийн сурагчдын Урлагийн наадмыг 2 өдөр зохион байгуулж 500 үзэгч үзсэн. Сумын ахмадын баярын арга хэмжээг зохион байгуулж, 120 ахмад хамрагдсан. Сумаас алслагдмал Алтан тал, Туяа багийн ахмадын өдөрлөгийг зохион байгуулж 150 ахмад хамрагдсан. Номын санч 60 ширхэг номоор ном соёлын арга хэмжээнд оролцож 12 ширхэг номыг уншигчдад олгож ажилласан. | 70 | 70 |
| | 2 | Орон нутаг судлах танхимуудыг иргэд, байгууллагуудад тогтмол хугацаанд, | 2021-2024 | | 20 | 70 | Сумын 100 жилтэй холбогдуулан музей орон нутаг судлах танхимыг шинэчлэн засварлаж, нэмэн дэлгэрүүлж 500 иргэн, 130 сурагч үйлчлүүлсэн. Мөн үндэсний бичгийн танхимыг | 70 | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хуваарийн дагуу үйлчилдэг болгоно. | | | | хамтатган байгуулж Шагайн наадгайг зохиож 103 сурагч хамрагдсан. | | |
| | 3 | “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээг хэрэгжүүлж, соёл, урлагийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 2020-2024 | Соёлын төв | | 50 | Соёлын бүтээлч сар аяныг зохион байгуулж иргэд олон нийтийг хамруулан урлаг соёлын нүүдлийн 3-н үйл ажиллагаа зохион байгуулж 750 хүн хамрагдсан. Сумын бүжиг 2024 буюу Тарагт зөв цаг бүжгийн клубын үйл ажиллагааг долоо хоногт 2 удаа зохион явуулж давхардсан тоогоор 1254 иргэд хамрагдсан. Эртэч Тарагтчууд номтой өглөө хэлэлцүүлгийг 50 төрийн албан хаагч, 13 иргэдийн дунд зохион байгуулсан. Соёлын бүтээлч сар аяны хүрээнд 3 ангийн 87 сурагчдад ном унших ач тус сургалт зохион байгуулж анги удирдсан багш нар, эцэг эхтэй хамтран ангийн номын санд баяжилт хийсэн ажилласан. | 50 | 50 |
| | 4 | Орон нутаг судлах музей, номын сангийн үйл ажиллагааг сайжруулж, үзвэр, номын фондыг нэмэгдүүлнэ. | 2020-2024 | Соёлын төв | 10 | 100 | Номын сан нь Lib4U программд 2600 ширхэг номыг нэг бүртчилэн хийж оруулан коджуулсан. Хандиваар ирсэн 100 ширхэг номыг зохиогчийн үсэг дараалллын гурван тэмдэгтийг хийж ажилласан. Шинээр авсан 15 ширхэг номыг мөн адил номын ажиллагаа хийж уншлагад гаргахад бэлэн болсон. Ном соёлын үйл ажиллагааг явуулын болон нүүдлийн хэлбэрээр зохион байгуулж ажилласан. Чанга уншлага, танхимын уншлагыг тогтмол зохион байгуулсан. Номын баяр, Бүтээлч уншлага зэрэг номын олон талт ажлуудыг хамтран хийж гүйцэтгэсэн. Шилдэг уншигч, шилдэг уншигч хамт олонд Нацагдорж тэмдэгтэн шалгаруулж ажилласан.<br>Номын сан нь 6500 ширхэг номтойгоос 698 ширхэг ном утга агуулга хуучирсан, уншлагад огт гардаггүй учир номыг актлах үндсэн хөрөнгөөс хасуулах хүсэлтийг сумын ИТХ-д өргөн мэдүүлсэн байна. | 100 | 100 |
| | 5 | Иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээг зайны болон нүүдлийн хэлбэрт оруулан, хөгжим, бүжгийн мэргэжлийн багшаар хангаж соёлын үйлчилгээг сайжруулна. | 2020-2024 | Соёлын төв | | 70 | Сумын түүхт 100 жилийн соёл урлагийн үйл ажиллагааг хариуцсан соёлын төв нь мэргэжлийн бүжгийн багшаар 70 сурагчдад наадмын нээлтийн бүжгийг заалган оролцсон. Үүний нөлөөнд Өвөрхангай аймгийн баяр наадмын нээлтэд оролцох 30 сурагчийг бэлтгэн оролцуулсан. Сумын багуудаар багийн өдөрлөг, багийн наадам, ахмадын баяр зэргийг техник хэрэгсэл, соёл урлаг, ном соёлын арга хэмжээг хамтатган зохион байгуулж ажилладаг. Давхардсан тоогоор 2056 иргэд оролцсон. Номын санч номын үзэсгэлэн байгуулж уншигчдад зайны болон нүүдлийн хэлбэрээр ном олголтыг хийж ажилладаг. Мөн сумандаа төрийн албан хаагчдад явуулын номын сангаар үйлчилдэг болсон байна. | 70 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | | **62.2%** | 71,1 |
| **1.2.ЭРҮҮЛ МЭНД** | | | | | | | | | |
| **Зорилт 1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | 1 | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 4,5 | 50 | 2024 онд Хөхний хорт хавдраас сэргийлэх үзлэг сургалтыг БОЭТ-тэй хамтран 39 эмэгтэйг хамрагдуулсан. Эрт элрүүлгийн үзлэг 5 дугаар сард Улсын 2 дугаар төв эмнэлэг Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулсан. Цахиур шүдний эмнэлэгтэй хамтран 0-18 насны хүүхдийн шүдийг эрүүлжүүлсэн. НҮБ-ын Хүүхдийн сан, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс санаачлан хэрэгжүүлж буй “Стрептококкийн ангина, фарингит, хэрэх өвчин, хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгийг оношлох” эрт илрүүлэг, үзлэгийг Өвөрхангай аймгийн 19 сумын ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж манай сумын 207 хүүхэд хамрагдаж зэрэг 1 гарсан.<br><br>Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг хэлэлцэж, тэргүүлэх чиглэлийг тодорхойлон хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Нийгмийн эрүүл мэнд тэргүүлэх чиглэл болох нь” зөвлөгөөнийг Хархорин суманд зохион байгуулж байна. Зөвлөгөөний үеэр дараах илтгэлүүдийг танилцууллаа. Эрүүл мэндийн салбарын бодлого, төлөвлөлтөд удирдлагын манлайлал, байгууллагын соёлыг чухалчлах нь Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх нь Эм эмнэлгийн хэрэгслийн тухай шинэчилсэн хуулийн танилцуулга Халдварт бус өвчнөөс сэргийлэх хянах нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц PEN HEARTS)-ын хэрэгжилт тус зөвлөгөөнд төлөөллүүд хамрагдаж байна. | 50 | 50 |
| | 2 | Иргэн бүрийг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорт хавдрын 7 төрөл, артерийн даралт ихсэх, чихрийн шижингийн эрт илрүүлгийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулна. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 15,5 | 30 | 2024 онд АГ-59,4% 2082 хүн, ЧШИҮ-98,3 хувь 1120, Хөхний үзлэгт 761 хүн хамрагдахаас 334 хүн хамрагдаж 43,9 хувь, умайн хүзүү хавдрын эрт илрүүлэг- нийт 185 эмэгтэй үзлэгт хамрагдахаас 35 эмэгтэй хамрагдаж 18,9 хувь, элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг 212 иргэнд хийсэн эдгээр үзүүлэлтүүд өмнөх жилийн мөн үеэс сайжирсан үзүүлттэй байна. Урьдчилан сэргийлэх үзлэг 39,5%-тай. | 30 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Иргэдийн дунд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүн амын зохистой хооллолт, илүүдэл жин, таргалалттай тэмцэх, давсны хэрэглээг бууруулах хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, хорт зуршил, мансууралтай тэмцэх арьс, харшлын өвчнийг бууруулах, осол, гэмтлээс сэргийлэх хэрх, хэрх төст өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ “Хеликобактер”-гүй гэр бүл арга хэмжээг авч хэрэгжүүлнэ | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | | 30 | 2024 онд халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 6 багийн иргэдийг гэрээр нь үзлэг хийж зөвлөгөө мэдээлэл өгсөн.<br>Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн тархалтын хандлагыг тодорхойлж, тандалт судалгааг жил бүр хийгдэн ажиллаж байна.<br>СГ-ийн шинжилгээг ЕБС-ийн сурагчдыг хамруулсан. | 30 | 30 |
| | 4 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах зорилгоор орчны эрүүл мэндийг сайжруулах, сүрьеэ өвчинтэй тэмцэх, БЗХӨ/ДОХ/тэмбүү өвчнийг бууруулах, томуу, томуу төст өвчнийг бууруулах, “Элэг бүтэн-Монгол” арга хэмжээ, Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах арга хэмжээтус тус авч хэрэгжүүлнэ | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 2,0 | 70 | 2024 онд Улаан бурханы эсрэг вакцинжуулалтад 1,8 сараас-7 хүртэлх настай хүүхдүүдэд 54 хувьтай хийсэн. Товлолын вакцинжуулалтыг сар бүр багуудаар тойрч хийж байна. Томуу томуу төст өвчний дархлаажуулалтад хүүхэд 99, архаг хууч өвчтэй 71 хүнд хийсэн.<br>БЗДХ өвчнөөс сэргийлэхийн тулд иргэдээс түргэвчилсэн оношлуураар тест үзэж байна. Хяналтад байгаа жирэмсэн эхчүүд 23 , цэргийн насны 150 залууд ДОХ/БЗДХ-ыг шинжилгээг хийсэн. Иргэдэд сургалт суртчилгааг цахим хаягаар хүргэж байна.<br>Айл өрхөөр явахдаа хуванцар савны хэрэглээг бууруулах чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан. Урт багийн айл өрхүүд ихэнх нь хувцанцар савыг хэрэглээнд хэрэлэхээс татгалзсан. | 70 | 70 |
| | 5 | Нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 2,0 | 100 | Сумын нөхөн үржихүйн насны 618 эмэгтэйчүүдийн бүртгэлийг цахим программд оруулан жил бүр шинэчлэн баяжилт хийж, жилийн турш урьдчилан сэргийлэх үзлэг, өвчлөл, жса-гийн хэрэглээнд хөдөлгөөн хийж тэмдэглэн хянаж, 1-р шатны | 100 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэндийг хамгаалах эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | урьдчилан сэргийлэх үзлэгт 80%-ийг хамруулан 2 дугаар шатлалд үзүүлэх эмэгтэйчүүдийг 100% нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан хяналтад авч,эмчлэн эрүүлжүүлэлтэд хамруулан хянаж байна.<br><br>Өсвөр насны охид, 20-60 насны эмэгтэйчүүдийг хөхний үзлэгт хамруулан мэдээлэл өгч, сургалтанд 2 удаа хамруулан, гарын авлага материалаар хангаж, хөхөө өөрөө шалгах аргад сурган бүртгэл хийж хэвшүүлсэн.<br><br>Цэргийн насны нийт 78 иргэнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Мөн 6 багаар нийт 564 эрэгтэйчүүдэд анхан шатны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна.<br><br>Нөхөн үржихүйн насны нийт эмэгтэйчүүдэд “ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТ”, “ОХИДИЙН ЭРҮҮЛ МЭНД”, “БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРТ ӨВЧИН”-ний талаар мэдлэг олгох, жирэмслэхээс сэргийлэх аргад сургах сургалтын жилийн төлөвлөгөө гарган батлуулж, эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл, сургалт сурталчилгааг 6 удаа хийж 450 эмэгтэйг хамруулж жирэмслэхээс сэргийлэх аргад сургасан. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэтэйчүүдийг Эрүүл мэндийн сайдын 11А маягтаар бүртгэн,15-49 насны эмэгтэйчүүдийн программд шивж оруулан тогтмол хянаж байна.<br><br>Зорилтот бүлгийн Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргад жил бүр бүрэн хамруулсан жирэмснээс хамгаалах аргын хэрэглээ 100 хувьтай байна.<br><br>Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн тайланг улирал бүр Эрүүл мэндийн газарт явуулж, нөөцөөр хангагдсан. | | 100 |
| Зорилт 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлнэ. | 1 | Эрүүл мэндийн төвд хэт авиан оношлогооны аппарат, AED төхөөрөмж, шээсний анализатор, сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 4,6 | 70 | 8 сая төгрөгний иммунологийн аппарат, 3.000.000 төгрөгний сэргээн засахын эмчилгээний ор авсан. 2022 онд ЭХО-ны зөөврийн аппарат Эрүүл мэндийн яамнаас өгсөн. | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Эрүүл мэндийн салбарт эмнэлзүйн олон улсын стандарт UpToDate систем, бүртгэл, хяналтын цахим тогтолцоог нэвтрүүлэн, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 1,3 | 70 | Тарагт эрүүл мэндийн төв цахим хуудсаар дамжуулан иргэдэд тухай бүр шинэ мэдээлэл хүргүүлж байна. Мөн UPTODATA программыг эмч мэргэжилтэнгүүдэдээ суулгаж, бүртгэл үүсгэж өдөр тутмын хэрэгцээндээ ашиглаж байна.<br>119.mohs.mn, Burtgel.mohs.mn хаягуудад өглөө бүр мэдээ, шинжилгээний хариуг тухай бүр шивж оруулж байна. Бусад CMA программ тухай бүр ашиглаж байна. | 70 | 70 |
| | 3 | Эрүүл мэндийн төвийг зөөврийн хүчилтөрөгчийн баллонтой болгох | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 15,0 | 100 | 2024 онд зөөврийн хүчилтөрөгчийн хошуу 1 ширхэг хандиваар өгсөн. | 100 | 100 |
| | 4 | Эрүүл мэндийн төв, багийн эмч нарыг шаардлагатай эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмж, унаагаар хангаж иргэдийг эрүүл мэндийн үйлчилгээнд жил бүр үнэ төлбөргүй хамруулна. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 35,0 | | 2024 онд бүрэн тоноглогдсон Patrol машинтай болсон.Бүх багийн эмч нарыг зөөврийн нөөтбүүкээр хангасан. | 100 | 100 |
| Зорилт 3. Цахим эрүүл мэнд, эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлж, яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг хөгжүүлнэ. | 1 | Сумын Эрүүл мэндийн төвд мобайл технологийг нэвтрүүлнэ.<br>Оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 10,0 | 70 | Эрүүл мэндийн төвд мобайл технологи ЭМЯ болон ЭМГ-аас сургалтыг зохион байгуулж ашиглах тоног төхөөрөмжөөр хангасан. Үүнд зөөврийн ipad, зөөврийн эхо аппрат, зөөврийн нотебүүк, даралт хэмжигч, фовер банк, зөөврийн зүрхний цахилгаан бичлэг аппарат зэрэг тоног төхөөрөмжөөр хангаж алсын зайн оншилгоог хийж байна.<br>1,2,3,4,5,6 багийн өрхүүдээр тойрч мобайл технологоор үйлчилгээ үзүүлж байна. | 70 | 70 |
| | 2 | Жирэмсний нэрийн хяналт, цэргийн үзлэг, эрүүл мэндийн хяналт, бэлгийн замын халдварт өвчний хяналтын | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | - | 100 | Жирэмсний хяналтын программыг нэвтрүүлсэн. Үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | программуудыг нэвтрүүлнэ. | | | | | | | |
| | 3 | Яаралтай тусламж үзүүлдэг боловсон хүчний тоог нэмэгдүүлнэ. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | - | | Байхгүй болно. | - | |
| Зорилт 4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлэн, чадавхийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | 1 | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлнэ. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | - | 70 | 2024 онд орон нутгийн нэмэгдэл 40 хувиар олгож байна. Эрүүл мэндийн төвд дутагдалтай байгаа ажлын байрыг зарласан. 20 албан хаагчдын орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. | 70 | 70 |
| | 2 | Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын улирлын урамшуулал, ур чадварын нэмэгдлийг тэдгээрийн мэдлэг, ур чадвар, харилцаа, хандлага, ёс зүйн үнэлгээтэй уялдуулан олгодог тогтолцоонд шилжүүлнэ. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 37,0 | 90 | 2024 онд бүх ажилчдын хурал, цаг үеийн асуудлын талаар болон эмч мэргэжилтнүүдийн сахилга дэг журмыг сайжруулах талаар мэдээлэл солилцож, тэмдэглэл хөтлөж, ажлын хариуцлага сайжруулах, ажил эрчимжүүлэх, цалин урамшууллыг нэмэгдүүлэх гэх мэт олон чиглэлээр гарсан тушаал шийдвэр, албан мэдэгдлийг бүх ажилчдад танилцуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна 13 удаагийн хурлаар тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж 1ажилтанд сануулах арга хэмжээ аван ажиллаж байна. | 90 | 90 |
| | 3 | Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай орон тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 2,0 | | 2024 онд Эрүүл мэндийн газар болон Эрүүл мэндийн яам зохион байгуулж буй сургалтад эмч мэргэжилтнүүдийг цаг тухай бүрт хамруулж байна. | 30 | 30 |
| | 4 | Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжил, боловсролыг дээшлүүлэх цахим зайн сургалтын системийг хөгжүүлж, тэдгээрийн 70-аас доошгүй хувийг | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | - | 70 | Яаралтай тусламжийн сургалтад 1, эх хүүхдийн эрүүл мэндийн сургалтанд 1, зүрх судасны эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх сургалтанд 1, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтанд 1 албан хаагч тус тус алсын зайнаас суралцаж мэргэжил, мэдлэгээ дээшлүүлж байна. | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зайн сургалтад хамруулна. | | | | | | | |
| Зорилт 5. Зарим төрөлжсөн төвүүд болон сумдын Эрүүл мэндийн төвүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | 1 | Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг барих | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | | 0 | Бариагдаагүй болно. | 0 | 0 |
| | 2 | Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн авто машины тоог нэмэгдүүлэх | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 10 | 100 | 2022 онд суудлын жижиг оврын PROBOX маркийн автомашинтай болсон. 2024 онд Patrol Y61 машинтай болсон. | 100 | 100 |
| | 3 | Мэдээлэл, сургалт сурталчилгааны танхимыг тохижуулах | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | 10,0 | 30 | 2024 онд хандиваар 75 инч дэлгэцтэй болсноор эрүүл мэндийн сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна. | 100 | 100 |
| Дундаж үнэлгээ | | | | | | | | 60.7% | 71,7 % |
| **1.3.БИЕИЙН ТАМИР** | | | | | | | | | |
| Зорилт 1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ. | 1 | Сумын хэмжээнд төр, хувийн хэвшлийн байгууллагуудад “Биеийн тамир, спортын хамтлаг” байгуулан эрчимжүүлж, үйл ажиллагааг нь тогтмолжуулан дэмжлэг үзүүлнэ. | 2020-2024 | Төрийн байгуулла гууд | 2,0 | 90 | Жил бүр сумын Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн дунд гар бөмбөгийн тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Арвайн талын уухай шагайн харвааны багт сумын ЗДТГ-аас асар, Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлөөс шагайн харвааны зурхай өгч дэмжлэг үзүүлсэн. Шагайн харвааны баг маань аймаг, сумын тэмцээнүүдэд амжилттай оролцож байна. ЭМТ, СӨББ, ЗДТГ-ын байгууллагууд нь гар бөмбөгийн багтай. Энэ жил тус бүр бүсийн тэмцээнүүдэд амжилттай оролцсон. Байгууллагуудаас тэмцээнд оролцох зардалд дэмжлэг үзүүлсэн. | 100 | 100 |
| | 2 | Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох, заавал биелүүлэх норм, нормативын сорилыг насны ангиллаар жилд 2 удаа авч хэрэгжүүлнэ. | 2020-2024 | Эрүүл мэндийн төв | | 100 | СӨББ, ЕБС-ын сурагчид, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдээс бие бялдарын сорилыг хавар, намар гэсэн 2 удаагийн давтамжтай түүвэрлэж авсан. Нийт 300 гаруй хүүхэд, иргэд, албан хаагчид сорилд хамрагдсан. Төрийн байгууллагын албан хаагчдын ихэнх нь суудлын ажил эрхэлдэг байсан. Энэ нь албан хаагчдын бие бялдрын чийрэгжилт, биеийн жинд нөлөөлж байгаа нь сорилын үр дүнгээр батлагдсан. Нийт сорилд хамрагдсан иргэдийг БЖИ-р авч үзэхэд тураалтай 0,01%, хэвийн жинтэй 21%, илүүдэл | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | жинтэй 52%, таргалалтын 1-р зэрэгтэй 15%, таргалалтын 2-р зэрэгтэй 9,9%, таргалалтын 3-р зэрэгтэй хүүхэд 2,1% байна. Чийрэгжилтийн түвшингээр авч үзэхэд хангалттай сайн 85% хангалттай 9%, хангалтгүй 6% байна.<br><br>Үүнээс биеийн жингийн илүүдэлтэй буюу таргалттай , таргалах эрсдэлтэй албан хаагч ихэнх хувийг эзэлж байгаа нь ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх, биеийн тамир спортоор хичээллэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх амьдралын идэвхитэй хэв маяг дутагдаж байгааг үзүүлж байна.<br><br>Одоогоор ЗДТГ болон СӨББ-ын албан хаагчид тогтмол ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж байна. | | |
| | 3 | Нийтийн биеийн тамирын арга зүйчтэй болгож, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ | 2020-2024 | ЗДТГ | 6,0 | 0 | Орон тоо батлагдаагүй. Сумын хэмжээнд нийтийн биеийн тамирын асуудлыг ЗДТГ-ын Нийгмийн бодлогын мэргэжилтэн хариуцан ажиллаж байна.<br><br>2023 онд төрийн албан хаагчдын дунд “Өглөөний алхалт” сарын аяныг зохион байгуулсан.<br><br>2024 онд “Ажлын байрны дасгал хөдөлгөөн” аяныг албан байгууллагуудын дунд эхлүүлсэн байна. | 30 | 30 |
| | 4 | Биеийн тамирын зориулалтын зам, гадна талбай болон хүүхэд, залуучуудын спорт цогцолбор бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг нэмэгдүүлэн, нийтийн биеийн тамирын орчныг бүрдүүлнэ. | 2022-2024 | Төрийн байгууллагууд | 23,0 | 30 | Сумын цэцэрлэгт хүрээлэнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх зориулалттай тоног төхөөрөмжүүдийг байршуулсан. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын сургуулийн гадна бие тамирын талбайн засварыг хийсэн.<br><br>СӨББ-ын гадна талбайд хүүхдийн тоглоомын талбайг тохижуулсан.<br><br>Дартсын спортыг түгээн дэлгэрүүлэх, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Тарагт сумын “Оч дартсын клуб”-ыг байгуулав. Тус клуб нь Тарагт сумын 100 жилийн ойн хандиваар бүтээгдсэн бөгөөд одоогоор 19 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, аймаг улсын чанартай тэмцээн уралдаанд тогтмол оролцож байна. Мөн сар бүр дартсын чансаа оноо олгох тэмцээн, мэргэжлийн самбар, сумны сугалаа зохион байгуулах, бусад сумдын клубүүдтэй туршлага солилцох нөхөрсөг тэмцээн зохион байгуулах, клубийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог гишүүдийг шинэ самбараар шагнах, урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулж байна. Тус клуб нь 2024 оны 03 сард байгуулагдсан ба түүнээс хойш дартс сонирхогчдын, самбарын, чансаа оноо олгох гэх мэт нийт 20 гаруй | 30 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тэмцээнийг нээлттэй зохион байгуулж давхардсан тоогоор 600 гаруй иргэдийг хамруулсан. | | |
| | 5 | Миний нутаг сайхан спортын наадмыг 2 жил дутам зохион явуулна | 2020-2024 | ЗДТГ, ЕБС | 6,0 | 90 | Хөдөөгийн малчдын дунд 2023 оны 10 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Урлаг, спортын бага наадмыг зохион байгуулсан. Нийт 120 малчин оролцож дүнгээр Туяа баг 1-р байр, Уртын баг 2-р байр, хүрэмт баг 3-р байрыг тус тус эзэллээ.<br>Тарагт сум үүсэн байгуулагдсны 100 жилийн ойн хүрээнд спортын 6 төрөлт тэмцээнийг Тарагт сумын 6 багийн иргэд, сумын харьяа, суманд ажиллаж, амьдарч байсан, мөн сумын хүргэн бэрүүдийг хамруулан 03 сарын 29-өөс 03 сарын 31-ний хооронд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд иргэд волейбол, софт волейбол, дартс, шатар, ширээний теннис, шагайн харваа гэсэн 6 төрлөөр оролцлоо. Волейболын төрөл нь 16-35 нас, 35-54 нас гэсэн 2 ангиллаар явагдсан бөгөөд нийт 34 баг буюу 237 тамирчин, софт волейболын 55-с дээш насны ангиллаар нийт 18 баг 92 тамирчин, дартсын төрөлд нийт 25 баг буюу 100 тамирчин, шатрын эрэгтэй төрөлд 22 тамирчин, эмэгтэй төрөлд 11 тамирчин, ширээний теннисний эрэгтэй төрөлд 23 тамирчин, эмэгтэй төрөлд 28 тамирчин, шагайн харваанд нийт 12 багийн 75 тамирчин тус тус оролцож, тус арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 588 тамирчин оролцлоо. | 100 | 100 |
| | 6 | Спортын олон төрөл тэр дундаа шинэ дутам хөгжиж байгаа спортын төрлүүдийг анхаарч дэмжин ажиллана. | 2022-2024 | ЕБС | | 100 | Чөлөөт бөхийн олон улсын хэмжээний мастер, Москвагийн олимпын тавдугаар байрны шагналт аймгийн арслан Ө.Насанжаргал волейболын спортын олон улсын хэмжээний мастер С.Доржваанчиг арслан нар ирж хүүхдүүдтэй уулзалт хийж, сургалт хүмүүжлийн ажил, Олимпын талаар өргөн мэдлэг олгож бөх, волейболын арга техникийг зааж, нэг өдөр сургуультай хамтарч ажилласан.<br>- 2022 оны Өвөрхангай аймгийн өсвөрийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд дэд байр эзлэн мөнгөн медаль хүртлээ.<br>- ЕБС-ийн дэргэдэх шатрын клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 40x40 хэмжээтэй шатар өгсөн. Мөн шатрын спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор олон нийтийн үйл ажиллагаанд идэвх, санаачилгатай оролцож буй анги хамт олон, сурагчдад шатар дурсгав.<br>- Дартсын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, жигд тод клубийн нээлтийн тэмцээн, азийн аварга шалгаруулах OPEN | 100 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ASIA TOUR 2024 тэмцээнд сум орон нутаг, клубээ төлөөлөн оролцож буй тамирчдад клубийн зүгээс хоол, унааны зардлын дэмжлэг үзүүлэв. | | |
| Дундаж үнэлгээ | | | | | | | | 86% | 80 |
| **1.4.БОЛОВСРОЛ** | | | | | | | | | |
| Зорилт 1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, сургалтын болон үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, ажиллана. | 1 | Багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Багшийн хөгжлийн төв” байгуулж, түүнд тулгуурлан ахмад багш нарын идэвхи, оролцоотойгоор залуу багш, сурагчдад зориулсан дугуйлан, клуб ажиллуулна. | 2020-2024 | ЕБС | 2,4 | 70 | Багш хөгжлийн төвийг улсын төсвийн 20,0 сая төгрөгөөр засварласан. Ахмад багш Ө.Сүхбаатар 1 дүгээр анги даан ажиллаж байгаа залуу багш С.Нямдуламыг халамжлан хүмүүжүүлж 6 настай хүүхдийг уншиж, уншуулж, бичүүлж сургах арга зүйгээр дэмжлэг үзүүлэн өөрийн тэргүүн туршлагыг залуу үедээ түгээн дэлгэрүүлсэн. МУ-ын зөвлөх багш Ц.Март багшийн “Зөвлөх багшийн үйлчилгээ” сургалтад ЭХЦК бэлтгэх арга зүйд нийт 17 багш, 4 удирдах ажилтан сургууль дээр багш хөгжлийн танхимаар бүрэн хамрагдлаа.<br>- БАЗАН-ийн багш нар багш солилцоо хөтөлбөрт хамрагдан Хайрхандулаан сумаас ирж ажилласан ахмад багш Л.Шийлэгчимэд багштай хамтран нээлттэй хичээл зааж ахмад багшийн арга зүйгээс суралцлаа.<br>- Багш солилцоо хөтөлбөрийн хүрээнд залуу багш Г.Оюун эрдэнэ физикийн ахмад багш Баярсайханаас физикийн бодлого бодох, хичээл заах арга зүйгээс суралцлаа.<br>Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ 2024 оны 5 сард зохион байгуулагдаж 1-12-р ангийн 217 сураглцагч 14 багш хамрагдлаа. Байгууллагын гүйцэтгэл 76,6%, багшийн бичгийн шалгалтын гүйцэтгэл 59,6% үнэлэгдэж өмнөх оны гүйцэтгэлээс ерөнхий гүйцэтгэл 6,2%-иар, бичгийн шалгалтын үр дүн 12,4%-иар тус тус ахисан байна. Урамшуулал авч буй багш 7 байна. | 70 | 70 |
| | 2 | Сургууль, цэцэрлэгүүдийн цахилгаан хангамж, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар шинэчлэнэ | 2020-2024 | ЕБС | 43 сая | 30 | ЕБС-ийн сантехникийн засварын ажлыг Орон нутгийн хөгжлийн сангаас 50 сая төгрөгөөр хийхээр төсөвлөгдсөн болович тендер зарлагдаагүй хүлээгдэж байна. | 0 | - |
| | 3 | Цэцэрлэгт сантехникийн бүрэн засвар хийж, барилгад их засвар, өргөтгөл хийх. | 2022-2023 | СӨББ | | 50 | Цэцэрлэг үүсч хөгжсөний 60 жилийн ойн хандиваар 4 бүлэгт хэсэгчилсэн засвар хийгдсэн. Өргөтгөл барих болон их засвар хийлгэх саналыг сум орон нутаг болон гишүүдэд удаа дараа тавьж байгаа. Одоогоор хийгдээгүй. | 50 | 50 |
| | 4 | Туяа бага сургуулийг түшиглэн | 2022 | СӨББ | - | 30 | 2022 оны хувилбарт сургалтын нэг хэсэг, Туяа багийн төв дээр 2022 оны 6-р сарын 10-аас 2022 оны 7-р сарын 01 | 30 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургуулийн өмнөх боловсролын бэлтгэл анги нээнэ. | | | | | хүртэлх хугацаанд хувилбарт сургалтад үндсэн сургалтанд хамрагдаж чадаагүй 26 хүүхэд хамрагдуулсан. Хүүхдүүд гар угаах, шүд угаах, багш, найз нөхөдтэйгээ зөв харьцаж, хувцасаа зөв тайлж, өмсөж, эвхэн тавих, мэндлэх, хүндлэх зэрэг энгийн дадал хэвшилд сурсан.<br>Мөн харандаагаа зөв барих, дэвтэр номоо зөв тавьж бичих, 1-10 хүртэлх тоог нүдлэх, бичих, дүрс, зураг будах суралцах чадвар эзэмшин дуу, шүлэг, үлгэр, зүйр үг, оньсого, түргэн хэллэг, сурч үлгэрээр театрчилсан тоглолт хийж эцэг эхдээ тайлангаа тавьж ажилласан. | | |
| | 5 | Туяа бага сургуулийн гадна хашааг засварлаж, биеийн тамир, хүүхдийн тоглоомын талбай шинээр бий болгоно. | 2022-2023 | Туяа ЕБС | 5,0 | 50 | Туяа бага сургуулийн гадна талбайг Орон нутгийн хөгжлийн сангийн 18 сая төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн.<br>2024 онд Туяа бага сургуулийн гэрлийн монтажийг хөөн засварлаж гэрэлтүүлгээр бүрэн хангасан.<br>Сургуулийн дусал гойжсон тамбарын дээврийг бүрэн сольж, дотор заслыг хийж сургалтын таатай орчныг бүрдүүлсэн. | 50 | 50 |
| Зорилт 2. Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1 | Ерөнхий боловсролын сургуулиудыг шаардлагатай кабинет, лаборатори, цахим тоног төхөөрөмжөөр хангана. | 2020-2024 | ЕБС | 26,45 | 100 | 2021-2022 оны хичээлийн жилд кабинет ашиглах журмын дагуу бага боловсролын хүрээнд хүсэлт гаргасан 4, дунд ангийн 8 багшийн кабинетийг үнэлэн 5 кабинетийн \Монгол хэл, Математик, Байгалийн ухаан, эмэгтэй, эрэгтэй технологийн кабинетийн \ эрхийг сунгаж, англи хэл, нийгмийн ухаан орос хэлний кабинетуудыг шинээр баталлаа 2021-2022 оны хичээлийн жилд багш нар кабинетийн орчны тохижилтод 550000 төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн байна. Тарагт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1995 оны анхны 10-р анги төгчсөгчдөөс SAMSUNG брэндийн 55 инчийн ухаалаг телевиз 4 ширхэгийг өгсөн.Химийн лабораторийн өрөөг 1,100,000 төгрөгөөр засварлаж тохижууллаа. Тарагт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1995 оны анхны 10-р анги төгсөгчдөөс 6,400,000 төгрөгийн үнэ бүхий SAMSUNG брэндийн 55 инчийн ухаалаг телевиз 4 ширхэгийг өгснийг урлаг заал, багш хөгжлийн өрөө, бага ангийн 1 бүлэг, дунд ангийн 1 бүлэгт тус тус байршуулан цахим сургалтын тоног төхөөрөмжөөр ханган ажиллалаа. Үүний үр дүнд 1-12 дугаар ангийн бүх бүлгүүд 100 хувь цахим сургалт зохион байгуулах орчин бүрдсэн.<br>2022-2023 оны хичээлийн жилд бага боловсролын түвшинд математикийн кабинетыг цахим анги болгох зорилго тавин ажиллалаа. Энэ ажлын хүрээнд 9.872,000 төгрөгний худалдан авалтаар 65 инчийн “Ухаалаг дэлгэц”, 182700 төгрөгний худалдан авалтаар wifi цацагч худалдан авч цахим ангид байршуулж бага ангийн сургалтын анги танхимуудыг интернетээр бүрэн хангаад байна. Мөн математикийн агуулгын залгамж холбоогоор 710.000 төгрөгний үнэ бүхий | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авч цахим кабинетийн хэрэглэгдэхүүний баяжилтыг хийж сургалтад ашиглаж байна. 2023-2024 оны хичээлийн жилд нөхөн хангалтын төсөвөөр 9,889,000 төгрөгний үнэ бүхий 17 таблет худалдан авч цахим мэдлэ сургуулийн цахим ангид цахим сургалт зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. БШУ-ны яамны хөрөнгө оруулалтаар Физикийн судлагдахууны кабинетад 8.402.700 төгрөгний өртөг бүхий 40 нэр төрлийн тоног төхөөрөмж,хичээлийн хэрэглэгдэхүүнийг хүлээн авч сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>Кабинетийн үнэлгээнд бага боловсролын математик 95,3%, монгол хэл 91,7%, байгалийн ухаан 83,2%тус тус үнэлэгдэж цаашид үргэлжлүүлэн үйл ажиллагаа зохион байгуулахаар тэнцсэн.<br>2024-2025 оны хичээлийн жилд нөхөн хангалтын төсвөөр 9,889,000 төгрөгний үнэ бүхий 11 таблет худалдан авч бага боловсролын цахим ангид цахим сургалт зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>Боловсролын ерөнхий газраас 75 инчийн 2 смарт телевизор 4,972,690, зөөврийн компьютер 6ш 12,292,500 хөрөнгө оруулалтаар хангасан. | | |
| | 2 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангах, хатуу зөөлөн эдлэлийг шинэчлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ | 2021-2024 | ЕБС | 1,5 сая | 100 | 1-12 дугаар анги бүгд цэвэршүүлэгчтэй ус буцалгагчтай болсон. “Эрүүл биед саруул ухаан оршино” аяны хүрээнд сурагчид усаа зөв тогтмол ууж хэвшээд байна. Мөн дотуур байранд шүүлтүүртэй усны 2 төхөөрөмжийг төвийн цэвэр усны шугаманд холбож сурагчдын эрүүл аюулгүй, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлсэн. | 100 | 100 |
| | 3 | Сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгоно. | 2020-2024 | ЕБС, СӨББ | яам | 100 | СӨББ-ын стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болох шаардлагатай байгаа боловч олон жилийн элэгдэл хуучралтаас засан сайжруулахад хүрч байгаа. Иймээс 2023 оны 06 дугаар сард зураг төслийг нь хийлгүүлсэн байна. 2024 онд боловсролын санхүүжилтээр засварт орохоор төлөвлөгдсөн байна. Зураг төсөв хийгдээд 100 хувь хийгдсэн байна.<br>Боловсролын яамны санхүүжилтээр 233 сая төгрөгийн төсвөөр 2024 оны 06 сараас 08 сар хүртэлх хугацаанд ариун цэврийн байгууламжийг “Дуутын нуруу” ХХК хийж гүйцэтгэсэн. Хэрэглээ хэвийн явагдаж байна. | 100 | 100 |
| | 4 | Боловсролын байгууллагуудын | 2020-2024 | ЕБС | 0,42 | 70 | Хичээлийн байр дотуур байрын камеруудад засвар үйлчилгээ хийж, бүрэн ашиглаж байна. 3 камерийг шинээр тавьж, 30 | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хичээлийн болон дотуур байранд орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камерын тоог нэмэгдүүлнэ. | | | | | хоногийн бичлэгийг хадгалж, CD-нд хуулан архивлаж байхаар мэдээллийн технологийн багшид хариуцуулан өгсөн. Мөн камер ашиглалтын дэвтрийг хөтөлж байна. Сумын ИТХ-д зурагтай тайлан хүргүүлсэн. 2022-2023 оны хичээлийн жил эхлэн хичээлийн байрны гадна үүдэнд 1ш, дотуур байрын зүүн талд 1ш, дотор 1 ш нийт 420000 төгрөгний 3ш дүрс бичлэгийн хяналтын камерыг нэмэлтээр байрлуулан багш ажилтан сурагчдын эрүүл аюулгүй ажиллах, сурч хөгжих орчныг бүрдүүлэн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. | | |
| | 5 | Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайн тохижилтыг стандартын шаардлагад нийцүүлэх, тоглоом сургалтын хэрэглэгдэхүүний хангалтыг сайжруулна. | 2022 | СӨББ | 15,8 | 90 | 2022 онд тусгаж өгсөн орон нутгийн хөгжлийн сангийн 4,3 сая төгрөгийн үнэ бүхий гадна талын тоглоомыг хүлээн авч байрлуулан хүүхдийн чөлөөт цаг болон хичээлийн үйл ажиллагаанд ашиглах таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байна.<br>2023 онд ОНХС-ын хөрөнгө оруулалтаар шийдэж өгсөн 11,5 сая төгрөгний үнэ бүхий гадна талын хүүхдийн тоглоомыг худалдан авсан байна. | 90 | 90 |
| | 6 | 1-2 настай хүүхдийг яслид, 2-5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд /5 настныг заавал/ хамруулж, хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана. | 2021-2024 | СӨББ | - | 70 | СӨББ-д хамрагддаг 5 настай хүүхдүүдийг сургуульд бэлтгэгдсэн байдлыг СӨББ-ын бэлтгэл бүлгийн багштай хамтран оношлох үнэлгээ хийхэд нийт 17 хүүхдээс хангалттай 11, дундаж 6 байсан. 2022-2023 оны хичээлийн жилд СӨББ-д шинээр ахлах, бэлтгэл, дунд, бага бүлэгт 2017-2020 оны нийт 143 хүүхэд бүртгэгдэж хувилбартад 54 хүүхэд, 2 настай 23 хүүхэд, 3 настай 23 хүүхэд , 4 настай 25 хүүхэд ахлах бүлэгт, 5 настай 17 хүүхэд бэлтгэл бүлэгт тус тус бүртгэгдэн сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Хүүхдийн сургуульд бэтгэгдсэн байдлыг БШУС-ын А/280 дугаар тушаалын үнэлгээний аргачлалаар үнэлж судалгааг гарган ЕБС-тай хамтран ажиллаж байна.<br>2023 оны хичээлийн жилд СӨББ-д шинээр ахлах, бэлтгэл, дунд бүлэгт 2017-2021 оны нийт 141 хүүхэд бүртгэгдэж хувилбартад 43 хүүхэд, 3 настай 19 хүүхэд сургалтыг цахимаар зохион байгуулж, 4 настай 27 хүүхэд ахлах бүлэгт, 5 5 настай 35 хүүхэд бэлтгэл бүлэгт бүртгэгдэн тус тус бүртгэгдэн сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг БШУС-ын А/280 дугаар тушаалын үнэлгээний аргачлалаар үнэлж судалгааг гарган ЕБС-тай хамтран ажиллаж байна.<br>2-р улирлын гарааны үнэлгээ ахлах бүлэг 55 хувьтай, бэлтгэл бүлэг 68 хувьтай шалгагдсан<br>3-р улирлын үнэлгээгээр ахлах бүлэг 69 хувьтай, бэлтгэл бүлэг 72 хувьтай ахисан түвшинд үнэлэгдсэн байна.<br>2024 оны сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Математик-74%, Хэл яриа-54%, Байгаль нийгмийн орчин-46%, Дүрслэх-49%, Эрүүл мэнд- 25%, тус тус шалгагдсан. | | |
| | 7 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж, багшлах боловсон хүчнийг давтан сургах, мэргэшүүлэх, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ. | 2023 | СӨББ, ЕБС | | 30 | Цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд одоогоор бүртгэгдээгүй. Байгууллага дотроо адил боломж хөтөлбөр хариуцдаг албан хаагч сумын халамжийн ажилтнаас судалгаа авч хамтран ажиллаж байна. Сумын хэмжээнд цэцэрлэгийн насны 1 хүүхдийн судалгаа гарсан. | 30 | 30 |
| Зорилт 3. Сургуульд үйлчилгээний стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрдүүлж, бүх сурагчдыг үдийн хоолны хөтөлбөрт хамруулна. | 1 | Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ | 2020-2024 | ЕБС | 16,6 | 100 | 2022-2023 оны хичээлийн жилд 1-5 дугаар ангийн 113 хүүхэд, 2023-2024 оны хичээлийн жилд 122 хүүхэд 2024-2025 оны хичээлийн жилд 106 хүүхдэд тус тус үдийн хоол үйлчилгээг үзүүлж байна. Үдийн хоолны цэсийг бага боловсролын сургалтын менежер ахлах тогоочтой зөвлөлдөн 14 хоногоор гарган захирлаар батлуулан ажиллаж байгаа бөгөөд 5 өдөр халуун хоолоор үйлчилдэг. Сурагчдын үдийн хоолонд эрдэс бодис, амин дэм, илчлэг ккалаар баялаг халуун хоол, сүү, сүүн бүтээгдэхүүн, витаминлаг хоол ундыг өгч дархлааг нь дэмжин ажиллаж байна. Үдийн хоолны хөндлөнгийн хяналтын зөвлөлийг багш эцэг эх сурагчийн төлөөлөл бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр үдийн хоолны үйл ажиллагаанд хуваарийн дагуу хяналт тавьж ажиллуулж байна. Хяналтын зөвлөлөөс сурагчдын эрүүл зөв хооллох соёлд сургах зорилгоор “Хоолны шимт бодис” сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 1-5 дугаар ангийн нийт 98 сурагч хамрагдсан. Мөн сурагчдыг эрүүл зөв дадал хэвшилтэй болгох зорилгоор “Эрүүл шүд” аяны хүрээнд бага ангийн сурагчдыг үдийн хоолонд орсны дараа дотуур байрны угаалгын өрөөнд шүдийг угаалгаж хэвшүүлсэн байна. | 100 | 100 |
| | 2 | Урлаг заалыг үдийн хоолны заал болгон засварлаж, тохижуулах, хоол зүйч, хоол үйлдвэрлэлийн | 2020-2024 | ЕБС | 12,0 | 100 | Хоол үйлдвэрлэлийг дотуур байрны гал тогоогоор 2 ээлжээр үдийн цайг үдийн хоол болгон 5 өдөр халуун хоол цайгаар үйлчилж үдийн цайны чанарыг сайжруулан ажиллаж байна. Мөн сургуулийн урлаг заалыг Солонгосын КҮНСОН их сургуулийн сайн дурын нийгэмлэгийн оюутнууд өөрсдийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | технологич орон тоогоор ажиллуулна | | | | | зардлаар 12,000,000 төгрөгний мини театр болгон засварлаж өгсөн.<br>Дотуур байрны гал тогоогоор бага ангийн сурагчид эрүүл цэвэр орчинд хооллох боломжтой тул урлаг залыг үдийн хоолны зал болгох шаардлагагүй гэж үзсэн. | | |
| | 3 | Сургууль, цэцэрлэгүүдэд туслах болон хүлэмжийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2020-2024 | ЕБС | 6,5 | 100 | 2024 онд гадна талбайн хүлэмж болон ногооны талбайд хүнсний нарийн ногоо болох чинжүү, өргөст хэмх, улаан лооль, төмс тариалаж өөрийн орлогыг бүрдүүлэн цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэж эрүүл аюулгүй өөрийн хөрсөнд тарьсан ногоог хэрэглэж байна. Цэцэрлэгээс төрөн гарсан ахмадууд 2 сая төгрөгний үнэ бүхий 4*8 харьцаатай хүлэмж хандивласан. Тоон үзүүлэлт бичих | 100 | 50 |
| Зорилт 4. Боловсролын үйлчилгээг чанартай зохион байгуулж, сургалт, хүмүүжлийн ажлын чанарыг дээшлүүлж, их дээд сургуульд хүлээн зөвшөөрөгдсөн суралцагчийг бэлтгэнэ | 1 | Улсын төрөлжсөн олимпиадад багш, сурагчдыг амжилттай бэлтгэн оролцуулж, чадавхийг дээшлүүлнэ | 2020-2024 | ЕБС | 1,8 | 70 | 2020-2021 оны хичээлийн жилд суурь, бүрэн дунд боловсролын түвшинд 33 судлагдахуунаар улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давaанд 56 сурагч, 18 багш оролцсон. Мэдээллийн технологийн багш А.Осоржин 4-р байр, 12-р ангийн сурагч О.Түвшинтулга, С.Мэнд-Оюун, 9-р ангийн сурагч Б.Одсэргарав, Б.Оюунханд, Б.Нацагмаа нар амжилттай оролцож 1-10-р байрт жагссан. Бага боловсролын хүрээнд Өвөрхангай аймгийн хэмжээний 30 сургуулийн бага боловсролын багш сурагчдын дунд зохион байгуулагдсан БТА, МУ-ын тэргүүлэх багш Д.Чулуунсүрэн багшийн нэрэмжит математикийн аймгийн олимпиадад 1 багш, 5 сурагч хамрагдан амжилттай оролцлоо. Үүнд: сурагчийн төрөлд 1-р анги 8-р байр, 2-р анги 12-р байр, 3-р анги - 15-р байр, 4-р анги 12-р байр, 5-р анги 9-р байранд тус тус орлоо. Багшийн төрөлд Ц.Аззаяа багш 11-р байранд орсон.<br>Аймгийн төрөлжсөн олимпиадад 2023 оны 03 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд суурь, бүрэн дунд боловсролын түвшинд 13 төрөл, 53 ангилалд аймгийн төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд 56 сурагч давхардсан тоогоор\, 9 багш оролцсон. Нийт 32 сургуулийн багш,суралцагч оролцсоноос 12-рт эрэмбэлэгдэж өмнөх 2022 оны эрэмбээс 12 байраар ахисан амжилтыг үзүүллээ.Гаргасан амжилтуудаас дурдвал: Багш нарын төрөлд: Орос хэлний багш П.Бундхорлоо тэргүүн байр, Техник спортын сурагчийн төрөлд: Дизайн технологийн багш Ч.Өлзийбатын бэлтгэсэн сурагчдын бүтээл авто загвар тэргүүн байр, нисэх загвар гутгаар байр, 12-р ангийн сурагчийн төрөлд: Газарзүйн судлагдахуунаар сурагч Д.Жавзмаа Дэд байр мөн багш П.Бундхорлоо, Ч.Өлзийбат нар улсын олимпиадад амжилттай оролцсон.<br>2024-2024 оны аймгийн төрөлжсөн олимпиадад 2024 оны 12 дугаар сарын 13-22-ны өдрүүдэд суурь, бүрэн дунд | 90 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсролын түвшинд 13 төрөл, 53 ангилалд аймгийн төрөлжсөн олимпиадын 2-ын давааанд 56 сурагч \ давхардсан тоогоор\ , 9 багш оролцсон. Нийт 33 сургуулийн багш, суралцагч оролцсоноос 38,6%-ийн гүйцэтгэлтэй 24-р байрт эрэмбэлэгдэж өмнөх оны гүйцэтгэлийг 8,6% иар ахиулсан амжилтыг үзүүллээ. 2023-2024 оны хичээлийн жилд аймгийн Монгол хэл "Эх хэл- Эрдмийн түлхүүр". Математик " Тоо бодож оюунаа хөгжүүлье", Эрүүл мэндийн анги нийтийн олимпиадад 3-р ангийн 26, 4-р ангийн 25, 5-р ангийн 29 сурагч, нийт 80 сурагч, 3 багш оролцлоо. Олимпиадын сургуулийн дундаж гүйцэтгэл бага боловсролын хүрээнд Математик- 26,1%, Монгол хэл - 40,2%, Эрүүл мэнд - 41% -тайгаар үнэлэгдсэн. Монгол хэлний ахиц - 2,2%, Математикийн ахиц - 5,8% байна.<br>Дунд анги \6-9 анги\ давхардсан тоогоор 7 судлагдахуунаар анги нийтийн аймгийн олимпиадад оролцож:<br>-Монгол хэл-44.8%<br>-Математик-25.8%<br>-Түүх-44.7%<br>-Англи хэл-43.7%<br>-Орос хэл-48% \ Гутгаар зэрэг\-тай,<br>Ахлах анги \10-11 анги\ давхардсан тоогоор 3 судлагдахуунаар анги нийтийн аймгийн олимпиадад оролцож:<br>-Монгол хэл-64.48% \Дэд зэрэг\<br>-Математик-18.5%-тай тус тус шалгагдаж суурь боловсролын түвшинд-41.4%,бүрэн дунд боловсролын түвшинд-41.5%<br>Өмнөх хичээлийн жилээс 10% ахисан. Олимпиадын сургуулийн дундаж гүйцэтгэл Математик- 26,1%, Монгол хэл - 30,2%, Эрүүл мэнд - 41% -тайгаар үнэлэгдлээ.<br>2023-2024 оны хичээлийн жилд давхардсан тоогоор 15 багш, 35 суралцагч 14 судлагдахуунаар амжилттай оролцсон. Аймгийн төрөлжсөн олимпиадад 33 сургуулиас 38,6% гүйцэтгэлтэй 24-т эрэмбэлэгдсэн. | | |
| | 2 | Хүүхэд нэг бүрийг ёс зүйтэй бие хүн болгон төлөвшүүлэн, хүмүүжүүлэхэд багш, эцэг, эх, нийгмийн | 2023-2024 | ЕБС, СӨББ, Туяа бага сургууль | - | 50 | 2023 сургуулийн эцэг эхийн зөвлөлийн тэргүүлэгч, 12 гишүүдэд сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн талаар танилцуулан,1-12 дугаар ангийн нийт | 50 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажилтны хамтын оролцоог хангаж, сэтгэл зүйчийн орон тоотой болно. | | | | | 120 гаруй эцэг эх, асран хамгаалагчдад "Хүүхэд хамгаалалд эцэг эхийн оролцоо"сэдэвт зохион байгууллаа.<br><br>Үүний үр дүнд анги удирдсан багш нар ангийн эцэг эх асран хамгаалагчидтай уулзалт зөвлөмжийг хийж, хүүхдийн хүмүүжил төлөвшлийн талаар харилцан ярилцаж төгсгөлд нь сургуулийн сургалтын орчин,багш нарын ур чадвар, харилцаа хандлагын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч цаашид хамтран ажиллах талаар, сургалт хэлэлцүүлгийг хийв.<br><br>"Хүүхдийг болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх. чиглэлээр ахлах дунд ангийн сурагчдад "Сургуулийн хүүхэд хамгааллын бодлого,"Сурагчдын дүрмийн хэрэгжилт " Үе тэнгийн дээрэлхэлтийг зогсооё" Бусдыг хүндэтгэхийн учир" "Бэлгийн боловсролоо дээшлүүлэх нь", мэргэжил сонголтоо хэрхэн зөв шийдэх нь" сэдвээр төрийн болон ТББ-тай хамтран уулзалт ярилцлага, хэлэлцүүлгийг 9 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 419 сурагчид хамрагдсан.<br><br>Сургуулийн нийгмийн ажилтан ахлах дунд, бага ангийн нийт 34 сурагчдаас бүлгийн ярилцлага 8 удаа, эцэг эх асран хамгаалагч ар гэр бүлтэй ганцаарчилсан уулзалт ярилцлага, зөвлөгөөг давхардсан тоогоор 54 удаа, хийж сурагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг ханган үе тэнгийн дээрэлхэлт,гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж үе тэнгийн дээрхлэлт буурлаа.<br><br>Сурагч хүүхдүүдийнхээ эрүүл аюулгүй байдлыг хангахад багш сурагч эцэг эх асран хамгаалагчдын мэдвэл зохих "сургуулийн хүүхэд хамгааллын " бодлогын талаар сургуулийн эцэг эхийн зөвлөлийн 11 гишүүдэд хууль эрх зүйн сургалт мэдээллийг хийсэн. Мөн "Эцэг эхийн оролцоо"-т 7 хоногийн аяны хүрээнд нийт 64 эцэг эх Боловсролын шинэчлэгдсэн хуулиар сургалт хийж нийт сурагчийн болон эцэг эхийн эрх үүргийг танилцуулж сургууль дотуур байрны орчинд мэдээллийн 2 самбар байршуулан суртчилан ажиллаж байна. Нийт багш ажилтан 37, сурагч 216, эцэг эхчүүд 64 хамрагдлаа. Нийт эцэг эх сурагчдад Боловсролыг багц хуулиар 120 гаруй брошурыг хийж тараалаа. Эдгээр сургалт суртчилгаа хамтын ажиллагааны үр дүнд эцэг эхийн оролцоо, эерэг харилцаа хандлага нэмэгдлээ.<br><br>Сэтгэл зүйчийн орон тоо улсын хэмжээнд дутагдалтай мөн төсвийн хэмнэлт сурагчдын тоо цөөн бага тул орон тоо батлагдаагүй. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | 3 | “Шатар” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ | 2020-2024 | ЕБС | - | 100 | 2022 Дотуур байрын сурагчдын дунд шатар тоглож сурах сонирхолтой хүүхдийн тоо 8 аар нэмэгдэж шатрын дугуйланд нийт 16 сурагч хамрагдаж байна. Тус дугуйлан нь долоо хоногт 1-2 удаа дотуур байрандаа тогтмол хичээллэдэг болоод байна. Нэг тасаг нэг шатар аян өрнүүлэн энэ хичээлийн жилд дотуур байрын шатрын тоог 5-аар нэмэгдүүлэн дотуур байр нийт 8 шатартай боллоо.<br>Шатар хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор “Хөгжилтэй шатар” клубыг шатрын багш Э. Мичидмаа анхан болон дунд шат гэсэн ангиллаар удирдан хичээллүүлж байна. Дунд шатны сургалтад 1-5-р ангийн 24 сурагч, 6-8-р ангийн 12 сурагч хамрагдан шатрын бодлого бодож шатар нүүх, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэн ажиллалаа. Сурагчдын шатар тоглох сонирхлыг нэмэгдүүлэх шатрын нүүдэл заах чиглэлээр анхан шатны сургалтыг анги удирдсан багш нартай хамтран зохион байгууллаа. Анхан шатанд 18 сурагч хамрагдсан.<br>2023-2024 Биеийн тамирын багш Б.Алтанхуяг 1-5-р ангийн 117 сурагчдад шатрын нүүдлийг заах анхан шатны сургалтыг зохион байгуулж “Цодгор хүү” шатрын дугуйланг НТБН-ийн багш О.Төрболдтой хамтран хичээллүүлэн бага сурагчдын дунд шатар, даамны тэмцээнийг зохион байгуулаад байна. | 100 | 100 |
| | 4 | Ерөнхий боловсролын сургалтын чанарын үндэсний үнэлгээнд жил бүр амжилтаа ахиулан, сургуулиудыг олон улсын PISA үнэлгээнд хамруулж, улсын дунджаас дээгүүр үнэлэгдэх зорилт тавин ажиллана. | 2020-2024 | ЕБС | - | 50 | 2021-2022 оны хичээлийн жилийн анги дэвших шалгалтыг 2022 оны 6 сарын 6-17-ны хооронд зохион байгууллаа. Бага боловсролын хүрээнд анги дэвших шалгалт 3-р анги 42,3%, 4-р анги - 54% -тай үнэлэгдлээ. Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд сургуулийн нийт дундаж гүйцэтгэл-55,8% байна. 2022-2023 оны хичээлийн жилийн жилийн эцсийн анги дэвших болон төгсөх шалгалтыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгууллаа. Үүнд:<br>Бага боловсролын хүрээнд Анги дэвших шалгалт<br>3-р анги нэгдмэл агуулгаар 56,6%-ийн гүйцэтгэлтэй,<br>4-р анги Математик 55%, Нэгдмэл агуулга 53,1% -ийн гүйцэтгэлтэй<br>Төгсөх шалгалт:<br>5-р анги Математик 63% Монгол хэл, 73,1% Байгалийн ухаан 51,6% -ийн гүйцэтгэлтэй тус тус шалгагдлаа.<br>Суурь боловсролын түвшинд анги дэвших шалгалт:<br>6-р анги: Монгол хэл бичиг,уран зохиолын нэгдмэл агуулга-51.0%, Англи хэл \сургууль\-57%, | 50 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Математик-43.0%-ийн гүйцэтгэлтэй,<br>7-р анги: Монгол хэл бичиг,уран зохиолын нэгдмэл агуулга 52.0%, Физик \сургууль\-57%,<br>Математик-48.0%-ийн гүйцэтгэлтэй,<br>8-р анги: Монгол хэл бичиг,уран зохиолын нэгдмэл агуулга 58.0%, Сонгох хичээл \сурагч\-37.0%, Математик-40.8%-ийн гүйцэтгэлтэй,<br>Бүрэн дунд боловсролын түвшинд анги дэвших шалгалт:<br>10-р анги: Монгол хэл бичиг,уран зохиолын нэгдмэл агуулга 70.0%, Сонгох хичээл \сурагч\-65.0%, Математик-53.0%-ийн гүйцэтгэлтэй,<br>11-р анги: Монгол хэл бичиг,уран зохиолын нэгдмэл агуулга 73.0%, Англи хэл \сургууль\ -60.4%, Математик-75.0%-ийн гүйцэтгэлтэй,<br>Төгсөх шалгалт: Суурь боловсрол:<br>9-р анги :Математик- 67.5%<br>Монгол хэл-62.2%<br>Байгалийн ухаан 58.2%<br>Нийгмийн ухаан-69.9%<br>Гадаад хэл-57.2%<br>Бүрэн дунд боловсрол:<br>12-р анги :Математик 82.0%<br>Монгол хэл-86.8%<br>Сонгон судлах-81,6%<br>Гадаад хэл-80.0%-ийн гүйцэтгэлтэй тус тус шалгагдлаа.<br>2023-2024 оны хичээлийн жилийн жилийн эцсийн анги дэвших болон төгсөх шалгалтыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгууллаа. Үүнд:<br>Бага боловсролын хүрээнд Анги дэвших шалгалт<br>3-р анги нэгдмэл агуулгаар 53,2%-ийн гүйцэтгэлтэй,<br>4-р анги Математик 63,7%, Нэгдмэл агуулга 62% -ийн гүйцэтгэлтэй. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Төгсөх шалгалт:<br>5-р анги Математик 55,5% Монгол хэл, 63,7% Байгалийн ухаан 62,4% -ийн гүйцэтгэлтэй тус тус шалгагдлаа.<br>Өмнөх 2022 оны анги дэвших шалгалттай харьцуулахад 3-р анги 3,4% буурсан 4-р анги 8%-ахисан байна.<br>Аймгийн ангийн нийтийн Монгол хэл "Эх хэл- Эрдмийн түлхүүр". Математик " Тоо бодож оюунаа хөгжүүлье", Эрүүл мэндийн олимпиадуудад 3-р ангийн 26, 4-р ангийн 25, 5-р ангийн 29 сурагч, нийт 80 сурагч, 3 багшийн хамт оролцлоо. Олимпиадын сургуулийн бага боловсролын дундаж гүйцэтгэл Математик- 26,1%, Монгол хэл - 30,2%, Эрүүл мэнд - 41% -тайгаар үнэлэгдлээ. | | |
| | 5 | Сургуулийн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын санал санаачлагыг дэмжиж хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, бие даан бүтээлчээр суралцахуйд суралцах боломжийг нээн, сургуулийн харьяа уламжлалт өв соёл, хэл, сэтгэн бодох, техник технологи, оюуны спортын төрлийн клуб, төв, дугуйлан, секцэд хичээллэх сурагчдын тоог нэмэгдүүлнэ. | 2020-2024 | ЕБС, Туяа бага сургууль | 0,3 | 50 | 2023 оны 10 сарын 26-нд “Хүүхдээ сонсох индэр” childrens day үйл ажиллагааг зохион байгуулсан. Сургуулийн 6-12-р ангийн нийт 79 сурагч оролцсож дараах саналуудыг гаргаж холбогдох албан тушаалтанд хүргэж ажиллалаа.Үүний үр дүнд цахим орчинд нохойгоо уяж байх уриалгыг гаргаж түгээснээр айл өрхүүд амжилттай хэрэгжүүлж байна. Гадна тоглоомын талбайн эвдрэл гэмтлийг сургуулийн жижүүрүүд засварласан. Сумын гудамж хэсгийн гэрэлтүүлэг муу байгааг холбогдох албан тушаалтнуудад хүргэж ажилснаар гэрэлтүүлэг нэмэгдсэн.<br>2024 онд “НОМЫН САН- ХӨГЖЛИЙН ОРЧИН” аяны хүрээнд бага ангийн сурагчдыг ном унших зөв дадал хэвшилтэй болгох, зөв, хурдан, ойлгож унших чадварыг хөгжүүлэх зорилгоор IIV/1-V/1 - ны хооронд өглөө бүр 7.00-8.00 цагт "Эртэч хүүхэд" уншлагын цагийг зохион байгуулж 1-5- р ангийн нийт 123 сурагч хамрагдсан. Уншлагын цагаар үлгэр, эх уншуулж ойлгосноо анги нийтээр ярилцах, хэлэлцүүлэг хийх, бусдадаа асуулт тавих, үлгэрээс санаа, сургамж авах, сайн муу зан үйлийг ялгаж сургах, номын тэмдэглэл хөтлөх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж сурагчдыг хөгжүүлэн ажиллав. Уншсан номын тэмдэглэлээр анги бүр үзэсгэлэн гаргасан. 2. Хүүхэд багачуудын уран унших, зоион найруулж бичих чадварыг хөгэүүлэх чиглэлээр 1-5-р ангийн сурагчдын дунд "Уран жиргээ", 6-12-р ангийн сурагчдын дунд "Хүрэл тулга" тэмцээнийг мэргэжлийн багш нартай хамтран зохион байгууллаа. "Уран жиргээ" тэмцээнд бага ангийн 44 сурагч, "Хүрэл тулга" тэмцээнд дунд ахлах ангийн 24 сурагч хамрагдсан. 3. Дотуур | 50 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байрын багш, жижүүрүүдтэй хамтран дотуур байрны сурагчдад "Унших цаг" оройн уншлагыг таван долоо хоногийн турш зохион байгуулсан. Нийт 63 сурагч хамрагдаж 20 гаруй үлгэрийн ном богино өгүүллэг уншиж хэлэлцүүлэг, ярилцлагыг зохион байгуулсан. 4. Сурагчдын цөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх мэдлэгийн санд нэмэр оруулах зорилгоор 1-3-р ангийн сурагчдын дунд "Миний мэдэх үлгэрийн баатрууд" АХА тэмцээнийг зохион байгуулсан. Нийт 57 сурагч хамрагдсан. 5. "Номоо хайрлая" үйл ажиллагааны хүрээнд номоо хэрхэн цэвэрлэх сэлбэх, наах талаар видео бичлэгийг ангийн мэдээллийн группүүдээр дамжуулан байршуулж мэдээлэл түгээн ажилласан. 2024 онд Нийгмийн ажилтан, Эрүүл мэндийн багш нар Ирээдүйн доктор клубыг чиглүүлэн шүдний олимпиадад 22 сургуулиас 9 байрт шалгарлаа. | | |
| | 6 | Сумын засаг даргын нэрэмжит олимпиадыг орон нутагтаа зохион байгуулж, багш, сурагчдын чадавхийг дээшлүүлнэ | 2020-2024 | ЕБС, ЗДТГ | 0,6 | 30 | 2023 Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг сумын Засаг даргын нэрэмжит мини олимпиадад бага ангийн төрөлд: математикийн судлагдахуунаар О.Алтанцэцэг багштай 3а анги 56% гүйцэтгэлтэйгээр 1-р байр, монгол хэлний судлагдахуунаар Л.Эрдэнэчимэг багштай 1а анги 65% гүйцэтгэлтэйгээр 1-р байранд тус тус орлоо.<br>6-9 ангийн төрөлд: Монгол хэл бичиг судлагдахуунаар П.Бундхорлоо багштай 7а анги 57.6% гүйцэтгэлтэйгээр Тэргүүн байр, Физик судлагдахуунаар Г.Оюун-Эрдэнэ багштай 6а анги 70.0% гүйцэтгэлтэйгээр тэргүүн байр 10-12 ангийн төрөлд: Монгол хэл бичиг судлагдахуунаар Б.Пүрэвсүрэн багштай 10а анги 67.5% гүйцэтгэлтэйгээр Тэргүүн байр, Математик судлагдахуунаар Э.Туул багштай 11а анги 71.2% гүйцэтгэлтэйгээр тэргүүн байр тус тус шалгарлаа.<br>2024 онд зохион байгуулагдаагүй байна. | 30 | - |
| Зорилт 5. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгож, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | 1 | Салбарын албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрүүл мэнд хөдөлмөрийн үнэлэмж, орон байрны нөхцлийг сайжруулах асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | 2020-2024 | ЕБС | 15,9 | 70 | БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын А/238, А/340-р тушаалуудыг хэрэгжүүлэн багш нарыг эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд аймгийн төвийн Сидармед уламжлалын эмнэлэгтэй гэрээ байгуулан эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа. Нийт 16 багш, 7 ажилтан хамрагдсан.<br>Эрт илрүүлгийн багцын үзлэгт “Чинмэнд” эмнэлэгтэй гэрээ хийж, нийт 38 багш ажилтны 65% нь эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамрагдлаа. Цаашид эмчлүүлэх шаардлагатай багш ажилтнуудыг сумын ЭМТ- тэй хамтран өдрийн эмчилгээнд хамруулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>12 сард 4 багш, 8 ажилтан өдрийн эмчилгээнд хамрагдан эмчлүүлсэн байна. | 70 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Байгууллагын дотоод журмын дагуу эрт илрүүлгийн эрүүл мэндийн багцын үзлэг оношлогоонд хамрагдаагүй үлдсэн нийт 28 багш ажилтнуудыг 2 ээлжээр үзлэгт хамрагдах хуваарь гарган эхний ээлжийн 9 багш 8 ажилтан хамрагдсан. Багш ажилчдын эрүүл мэндийн үзлэг оношлогооны зардалд нийт 1,021,500 төгрөгийг эрүүл мэндийг дэмжих зардлаас зарцууллаа.<br>Багш ажилчдын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдэж нийт 6 хүнийг эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх боломжийг олгож байгууллагын дотоод журмын дагуу 5-10 хоногийн цалинтай чөлөө олгосон.<br>Багш ажилчдын дархлаа дэмжих зорилгоор 7 хоногийн 2 өдөр халуун аарц, чацарганаар үйлчилж байна. Залуу боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад сум орон нутгаас орон байрыг засварлан амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Гэр бүлээрээ шилжиж ирсэн залуу гэр бүлийн 2 багшид амьдрах хашааны орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Мөн тогтвор суурьшилтай ажиллах гэрээ хийж ур чадварын нэмэгдэл өгч ажиллуулж байна. | | |
| | 2 | Багш, удирдах ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх "Багшийн цахим кампус" зайн сургалтын системийг хөгжүүлж, багш нарын 70-аас доошгүй хувийг зайн сургалтаар мэргэжил, боловсролыг нь дээшлүүлнэ | 2020-2024 | ЕБС | 2,76 | 100 | 2024 оны хичээлийн жилд сургуулийн хэмжээнд 4 удирдах ажилтан 15 багш Aplus.mn сургалтад бүрэн хамрагдаж сургалтын гэрчилгээгээ 100% авсан. Бага боловсролын 4 багш өгүүлбэртэй бодлого заах арга зүйгээ сайжруулах зорилгоор Алдар сургалтын төвийн “ӨГҮҮЛБЭРТЭЙ БОДЛОГО БОДЬЁ” цахим сургалтад хамрагдан ажлын байрандаа багш өөрийгөө хөгжүүлэн ажиллалаа. Эдүтэн хөтөлбөрийн арга зүйн сургалтад сургалтын менежер 5 багшийн хамт хамрагдан Эдүтэн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Бага боловсролын 5 багш математик, монгол хэлний багш нар “Онлайн ба хосолсон сургалтын нөөцийг ашиглах арга зүй” сургалтад хамрагдсан. Бага ангийн 5 багш “ Зөв бичих дүрмийн арга зүй” онлайн сургалтад хамрагдаж ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэн онолын мэдлэг, арга зүйгээ хөгжүүлэн ажиллаж байна. Багш П.Батдулам “1-р ангийн хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамрагдсан. Бага боловсролын багш нарын "Сургалтын хэрэглэгдэхүүн хөгжүүлэх, турших, сайжруулах" МХБ-ийн үйл ажиллагааны хүрээнд 1-р ангийн -3 нэгж, 2-р ангийн- 5 нэгж, 3-р ангийн - 2 нэгж, 4-р ангийн- 4 , 5-р ангийн 2 нэгж нийт 16 нэгжийн сургалтын хэрэглэгдэхүүн тарааж өгөх материалыг багш нар хамтран агуулгын залгамж хүрээний дагуу хийж сургалтад ашиглан туршиж сайжруулан ажиллалаа. Сурагчдын цэвэр бичих чадварын хөгжүүлэх зорилгоор ахмад багш Д.Наранхүүд залуу багш | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Г.Наранчимэгийг дагалдуулан суралцуулснаар 3-р ангийн сурагчдын цэвэр бичих чадвар 10%-иар ахисан байна. 2024-2025 онд Удирдлага 2 менежерийн хамт 2024-2025 оны хичээлийн жилд уралдаан тэмцээн олимпиадад амжилттай оролцсон багш нарыг 3 сайдын 2021 оны 02 сарын 01-ны өдөр А/35, А/10, А/9 тушаалын дагуу хагас бүтэн жилээр үнэлж ур чадварын нэмэгдлийг өгч нийгмийн асуудлыг шийдлээ. Багш ажилтны “Байгуулагын соёл” 500,000 төгрөг, “Өөрчлөгдөхөд бэлэн үү Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” 10-12 ангид 500,000 төгрөгийн, Ангиараа амжилттай суралцъя 4 ангид 960,000 төгрөгийн гэх мэт багш сурагчдын хөгжлийг дэмжиж үе үе шаттай ажлуудыг зохион байгуулан багш, сурагчдыг чадваржуулан ажиллалаа. | | |
| | 3 | Багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Багш солилцоо” хөтөлбөрийг Туяа бага сургууль, сумын сургууль болон бусад аймаг, сумын сургуулиудтай хамтран хэрэгжүүлж багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ. | 2020-2024 | ЕБС, Туяа бага сургууль | 0,4 | 50 | “БАГШ СОЛИЛЦОО ХӨТӨЛБӨР” –ийг хэрэгжүүлэх зорилгоор Ханхөгшин бүсийн Хайрхандулаан сумын ЕБС-тай хамтран ахмад, тэргүүлэх зэрэгтэй багш нар туршлага солилцож арга зүйгээ түгээн дэлгэрүүлэн залуу багш нар мэргэжлийн багш нартай хамтран хамтын хичээл зааж, туршлага судлах үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд хамт олноо төлөөлөн гадаад хэдний МУ-ын Тэргүүлэх багш П.Бундхорлоо, залуу багш Д.Даваасүрэн, Г.Оюун-Эрдэнэ, П.Батдулам нар Хайрхандулаан сумын сургууль дээр туршлагаа түгээн дэлгэрүүлж, харилцан суралцаж хамтран ажиллалаа. Туршлага солилцох арга хэмжээнд 4 удирдах ажилтан,17 багш нийт 21 хүн хамрагдлаа.<br>Залуу багш нарын арга зүйг дэмжих, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор ур чадварын уралдааныг зохион байгууллаа. Ур чадварын уралдаанд нийт 8 багш оролцож Биологийн багш Д. Даваасүрэн 6-р ангид хичээл зааж тэргүүн байр эзэллээ. Ханхөгшин бүсийн сургуулиудын хооронд зохион байгуулагдсан багш нарын “УР ЧАДВАРЫН УРАЛДААН”-нд нийт 8 сургуулийн 8 багш нар оролцсоноос залуу багш Д. Даваасүрэн 3-р байранд шалгарлаа. БАЗАН-ийн багш нар Багш солилцоо хөтөлбөрт хамрагдан Хайрхандулаан сумаас ирж ажилласан ахмад багш Л.Шийлэгчимэд багштай хамтран Нээлтэй хичээл зааж ахмад багшийн арга зүйгээс суралцлаа. Мөн ахмад багш Л.Шийлэгчимэд залуу багш О.Алтанцэцэг, С.Нямдулам нарын хичээлд сууж багш нарт арга зүйн зөвлөгөө өгч 5 хоногийн турш хамтран ажилласан. 2024-2025 оны хичээлийн жилд Туяа бага сургуулийн багш нартай хамтын ажиллагааг төлөвлөн бага боловсролын сургалтын менежер М.Нарангэрэл Туяа баг сургууль дээр очиж 1 өдөр багш нарын хичээлд сууж арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан. Мөн 11 сард Туяа бага сургуулийн багш нар 7 | 50 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хоногоор ээлжлэн ирж ЕБС-ийн бага ангийн багш нартай хамтран ажиллаж арга зүй, мэдлэг туршлагаа солилцон ажилласан.Туяа бага сургуулийн 5 багш бага ангийн 5 багш нийт 10 багш сургуулийн нярав, тогооч зэрэг 4 ажилтан хамрагдан мэдлэг, чадвар, туршлагаа солилцоод байна. Багш солилцоо хөтөлбөрийн хүрээнд Туяа багийн ЕБС-ийн 5 багш нярав, тогоочийн хамт 1 сарын хамтдаа хөгжиж, хамтдаа суралцъя аяныг өрнүүлж хамтын хичээл үйл ажиллагаа төлөвлөн хийж арга зүй туршлагаа солилцож хамтран ажиллалаа. Нийт 16 хүн хамтарч ажиллаж манай сургуулийн бага ангтйн заах аргын нэгдэл хамтран ажиллаж арга зүй туршлагаа түгээн дэлгэрүүлсэн. | | |
| | 4 | Багш нарын ажлын үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор “Чадварлаг багш” арга хэмжээг зохион байгуулж, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээр шинэ бүтээл, оновчтой санал /инноваци/ нэвтрүүлсэн багш, удирдах албан хаагч нарт урамшуулал олгоно. | 2020-2024 | ЕБС, СӨББ, Туяа бага сургууль | - | 100 | 2024 онд Ханхөгшин бүсийн хэмжээнд багш нарын дунд зохион явуулсан “Шинэлэг санаа шинэ бүтээл” уралдаанд чулуугаар хийсэн зүйлээрээ үзэсгэлэн гаргаж Тэргүүн байранд орсон. Байгууллага дээрээ багшийн туслахуудын дунд хөгжөөн баясахаар нээлттэй хичээл явуулж, бүлгийн багш нарын дунд илтгэлийн уралдаан зохион явуулах зэрэг үйл ажиллагааг удаа дараа явуулж бие биенээсээ суралцах харилцан туршлага солилцуулан ажиллаж байна. Мөн Жаргалант багийн цэцэрлэг дээр зохион явуулсан “Цэгээр наадъя” сургалтад багш болон багшийн туслахуудыг хамруулсан. 2 сард БШУГ-аас зохион байгуулсан Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд англи хэлний багш М.Энхмаа Улаанбаатар хотод 14 хоногийн вакумжуулсан сургалтад хамрагдсан<br>Технологийн багш Ч.Өлзийбат, Ч.Сугар, Мэдээллийн технологийн багш А.Осоржин нар хамтран Монгол банкнаас зохион байгуулсан Бүтээлийн уралдаанд амжилттай оролцож Шилдэг бүтээлээр шалгарсан. Энэхүү бүтээлд Хурамтлалын хайрцаг, хадгаламжийн дэвтэр хөтлөлт, хадгаламж эхлүүлэх санамжаар номын хавчуурга хийж оролцсон. Thanks student клубээс санаачлан хэрэгжүүлж буй “Гараа” ухаалаг боловсролын системийг дэмжих төсөлд амжилттай оролцож 20 аймгийн 93 сумаас шилдэг 6-т шалгарсан.Мөн А.Осоржин багш нь 9-р сард Голомт банкнаас зарласан бүтээлийн уралдаанд амжилттай оролцсож Шилдэг бүтээлийн шагнал авсан. Миний Өвөрхангай аяны хүрээнд зохион байгуулагдаж буй Шинэ бүтээл оновчтой санал уралдаанд Технологийн багш Ч.Өлзийбат , шавь Т.Батзориг нар “Морины шүтээн”-ийг урласан.<br>Багш Ц.Аззаяа 2-5-р ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан STEM сэтгэх чадварын аймгийн уралдаанд бэлтгэсэн шавь нар нь 4-5 - р ангийн төрөлд 1-р байрт орсон. | 90 | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Б.Алтанхуяг багшийн бэлтгэсэн шавь нар аймгийн өсвөрийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцож 2-р байр мөнгөн медаль авсан .- Залуу багш нарын дунд зохион байгуулагдсан “Ур чадвар”-ын сургуулийн уралдаанд биологийн багш Д.Даваасүрэн 1-р байрт орж бүсийн ур чадварын уралдаанд оролцох эрхээр шагнагдаж бүсийн “Ур чадвар”-ын уралдаанд оролцон 3-р байранд орлоо. Гавьяат багш Ё.Соёлмаагийн нэрэмжит бүсийн математикийн олимпиадад Багш А.Тамжидын бэлтгэсэн 6-а анги 3-р байранд орлоо. 2023 оны хичээлийн жилийн ЭЕШ-д Нийгмийн ухааны багш Б.Пүрэвсүрэнгийн бэлтгэсэн сурагч Д.Сугармаа Нийгэм судлагдахуунаар 711 оноотой шалгагдаж 1 удаагийн мөнгөн тэтгэмж авах болзол хангалаа. 2023-2024 оны хичээлийн жилд Ханхөгшин бүсийн “Тоо бодож оюунаа хөгжүүлье” математикийн анги нийтийн олимпиадад бага ангийн төрөлд: О.Алтанцэцэг багшийн бэлтгэсэн 4а анги 3-р байр Ахлах ангийн төрөлд А.Тамжид багшийн бэлтгэсэн 12а анги 3-р байр<br>“Эх хэл – эрдмийн түлхүүр” монгол хэлний олимпиадад А.Батцэцэг багшийн бэлтгэсэн 11а анги 2-р байр<br>“Гадаад хэл хөгжлийн түлхүүр” орос хэлний олимпиадад П.Бундхорлоо багшийн бэлтгэсэн 8а анги 3-р байр<br>Бага ангийн багш нарын аймгийн “МОНГОЛ ХЭЛ”-ний олимпиадад багш О.Алтанцэцэг бага боловсролын 25 багш орсноос 4 -р байранд орсон амжилтыг үзүүлсэн.<br>Ханхөгшин бүсийн бага ангийн багш нарын “МАТЕМАТИК”-ийн олимпиадад бага ангийн 2 багш оролцож багш О.Аланцэцэг 3-р байранд орж “ХҮРЭЛ МЕДАЛЬ” хүртсэн<br>Сурагчийн төрөлд: А.Тамжид багшийн бэлтгэсэн 8а ангийн сурагч Б.Энхриймаа 1-р байр<br>Аймгийн “Идэрчүүдийн аварга шалгаруулах воллейболл”-ын тэмцээнд Б.Алтанхуяг багшийн бэлтгэсэн сурагчид 4-р байранд<br>Гавъяат багш Д.Соёлмаа багшийн нэрэмжит бүсийн “МАТЕМАТИК”-ийн олипиадад О.Алтанцэцэг багштай 4а анги 3-р байр<br>Хайрхандулаан суманд зохион байгуулагдсан “МАТЕМАТИК”-ийн бүсийн олимпиадад 1-р ангийн төрөлд сурагч Э.Анхмаа 12 оноогоор 4-р байр, Ж.Амарбаясгалан 11 оноогоор 5-р байр эзэлсэн амжилтыг тус тус үзүүлсэн<br>Бага боловсролын залуу багш нарын дунд “Ур чадварын уралдаан”-ыг зохион байгуулж залуу 4 багш хамрагдан О.Алтанцэцэг багш тэргүүн байранд орж аймгийн залуу багш | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нарын дунд зохион байгуулагдах “Ур чадварын уралдаан”-д оролцох эрх авсан. Энэ хичээлийн жил Бага ангийн ЗАН үйл ажиллагаагаараа бусдыгаа манлайлан шилдэг заах аргын нэгдлээр шалгарсан. | | |
| Зорилт 6. Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. | 1 | Насан туршийн боловсрол олгох сургалтыг бизнес, амьдрах ухаан, хүний хөгжил, ёс суртахуун, гоо зүй, гэр бүл, байгаль орчны, иргэний боловсрол (эрх зүй, эрүүл мэнд, гамшгаас хамгаалах) олгох чиглэлээр сургалтын олон талт хэлбэрээр зохион байгуулна. | 2020-2024 | ЕБС | - | 70 | Хүн амын мэдлэг, чадварыг дээшлүүлэх хүрээнд насан туршийн боловсролын 5 чиглэлээр 15 төрлийн 13 сургалт, 1 аян, цахим контент 11 үйл ажиллагаа олон нийтэд түгээсэн. 2022 онд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр 2 суралцагч гэрээр болон зайнаас суралцан 1 суралцагч бага боловсрол буюу 4-р анги, 1 суралцагч 6-р ангийн боловсролыг нөхөн эзэмшсэн. Бичиг үсгийн боловсрол олгох сургалтад 35-40 насны 3 иргэн хамрагдаж бичиг үсгийн боловсролоо дээшлүүлсэн. 2023 онд насан туршийн боловсролын 7 чиглэлийн хүрээнд 12 удаагийн мэдлэг, ойлголт олгох 60 минутын 10 нэр бүхий сургалтыг 396 хүнд олголоо. 2023-2024 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 1, 5 дугаар ангид 1 сурагчийг тус тус шинээр бүртгэж боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Бага боловсролын багш О.Алтанцэцэгтэй гэрээ байгуулан нийт 84 цагийн танхимын сургалтыг зохион байгууллаа. Бага боловсролын 1-5-р ангийн сурагчид Эко хичээлийн хүрээнд мод тарих аргачлалд суралцан сургуулийн урд талбайд 10 ширхэг гоёлын мод суулгасан. Эцэг, эхийн хамтын дэмжлэгтэйгээр 610,000 төгрөгөөр 180 ширхэг мандлын цэцгийн үрсэлгээ авч суулган сургууль орчмын ногоон байгууламжид хувь нэмрээ оруулсан. | 70 | 100 |
| | 2 | Насанд хүрэгчдийн тасралтгүй сургалт болон ерөнхий боловсрол нөхөн олгох сургалтыг зохион байгуулна. | 2020-2024 | ЕБС | - | 70 | Хүрэмт багийн 1 иргэнд бичиг үсгийн боловсрол олгох сургалтыг математик, монгол хэлний судлагдахууны хүрээнд нийт 30 цагийг бие даах хэлбэрээр судлууллаа. Тарагт сумын Насан туршийн боловсролын нэгж пэйж хуудсанд my.future.mn, mycareer.mn сайтуудад байршсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээлэл, постер, бичлэг зэргийг хуваалцан олон нийтэд түгээсэн. Мөн боловсролын ерөнхий газрын пэйж хуудсаас цаг үеийн мэдээ мэдээллүүдийг хуваалцж нийт 20 мэдээллийг 440 хүнд хүргэн 71 хандалт авсан. 18 удаагийн сургалтаар | 70 | 70 |
| | 3 | Монгол бичигт суралцах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлнэ. | 2020-2024 | ЕБС | - | 30 | ЕБС-ийн мэргэжлийн багш нарыг түшиглэн сумын нийт төрийн албан хаагчдад танхим болон цахим хэлбэрээр үндэсний бичгийн анхан, дунд шатны унших,бичих чадварын сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. Сургалтын үр дүнд нийт төрийн албан хаагчдын 65% унших чадвартай болов. 2023 “Үндэсний бичгээр үлгэрлэе” монгол бичгийн уралдааны хүрээнд насанд хүрэгчид болон 6-12 дугаар ангийн сурагчдад цэвэр бичиг, минутын уншлага явуулахдаа харилцан туршлага солилцож цаашид сайжруулах алдаа, | 30 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дутагдлыг хэлэлцэж Монгол хэл, уран зохиолын багш нар зөвлөмж хүргэсэн. Уралдаанд насан хүрэгчдийн ангилалд 17 иргэн, 6-12 ангийн сурагчдын ангилалд 14 сурагч оролцсон. 2023 оны 11 сард нийт төр албан хаагчдаас монгол бичгийн унших, бичих, чадварын түвшинг тогтоох оношлох үнэлгээг аймгийн насан туршийн боловсролын багштай хамтран зохион байгууллаа. Нийт 102 төрийн албан хаагчид хамрагдсан. Үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор монгол бичгийн 2 төрлийн цуврал цахим хичээлийг насан туршийн боловсролын пэйж хуудас болон Таргат сумын иргэдийн идэвхтэй ашигладаг фэйсбүүк группд байршуулж үндэсний бичигт суралцах уриалга гаргасан. Багш сурагчид албан хаагчдад үндэсний бичгийн БИЙРИЙН БИЧЛЭГ-ийн анхан шатны сургалтыг зохион байгуулж 10 багш ажилтан, 14 сурагч нийт 24 хүн хамрагдаж батламж авсан. 14 сурагчийн сургалтын төлбөр 320,000 төгрөгийг сургуулийн хүүхэд хамгааллын зардлаас санхүүжүүлж, 10 багш ажилтан сургалтын төлбөр 200,000 төгрөгийг хувиасаа гаргаж үндэсний бичгийн чадвараа ахиуллаа. 2025 онд албан бичгийг хос бичгээр бичих ажлын хүрээнд ЕБС-ийн захирлын тушаалын баланк бичгийг туршилтын хугацаанд үндэсний бичгээр хөрвүүлэн хос бичгээр хөтөлж хэвшиж байна. 2024 оны хичээлийн жилд хичээлийн байрны гаднах хаягийг 2,300,000 төгрөгийн хандиваар мөн анги танхим, албан өрөөний хаягийг үндэсний бичгээр бичиж хаягжуулсан. | | |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | | 67.9% | **71,1** |
| **1.5. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ** | | | | | | | | | |
| Зорилт 1. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхижсан гэр бүлийг төлөвшүүлнэ. | 1 | Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, нотолгоонд тулгуурлан гэр бүлийн боловсрол олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | - | 70 | Залуучуудын хөгжлийг дэмжих ажлын хүрээнд:<br>1. Таргат сумын хэмжээнд залуучууд амьдарч, ажиллахад тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдвэрлэх гарц гаргалгаа" сэдвээр цахим хэлэлцүүлгийг 2023 оны 08 сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Таргат сумын 6 багийн нийт 40 гаруй залуучуудын төлөөлөл оролцсон ба цаашид жилд 1-2 удаа Залуучуудын дуу хоолойг сонсох, тогтмол хэлэлцүүлэг хийж байхаар төлөвлөн ажиллаж байна.<br>2. 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Таргат сумын СӨББ болон ЕБС-ийн эцэг эхчүүд, залуу гэр бүлд зориулан "Жаргалтай гэр бүл" өдөрлөгийг зохион байгууллаа. Тус | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдөрлөгт нийт 30 гаруй эцэг эхчүүд оролцсон бөгөөд 80 гаруй хувь нь 30-аас доош насны эцэг эхчүүд байна.<br><br>3. Төрийн албан хаагчдад Өвөрхангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн Сургагч багш Б.Сүрэнхүү Ажил амьдралын баланс, зорилгоо тууштай хэрэгжүүлэх нь сэдвээр сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 35 төрийн албан хаагч хамрагдлаа.<br><br>4. Хамтарсан багийн хяналтад байдаг харилцааны зөрчилтэй, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэр бүлүүдийг аймгийн ХГБХХГ-ын Сэтгэл зүйчтэй холбон зуучилж хагас жилийн байдлаар 5 залуу гэр бүл сэтгэл зүйчээс зөвлөгөө мэдээлэл аван, үйлчилж байна. | | |
| | 2 | Залуу гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагыг дэмжин хамтран ажиллана. | 2020-2024 | ЗДТГ | | 70 | Аймгийн Гэрлэх ёслолын ордон болон Хүүхэд, гэр, бүл, залуучуудын хөгжлийн газраас суманд залуу гэр бүлүүдэд “Гэр бүлийн үнэ, цэнэ” сургалтыг зохион байгуулж 50 залуу оролцсон.<br><br>Гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгох, гэр бүлийн хөгжлийг дэмжих зорилгоор “Хамтдаа жаргалтай” өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр аймгийн НТСТ-ийн Сургагч багш Б.Сүрэн “Сэтгэлийн холбоогоо бэхжүүлэх нь” сэдэвт сургалтыг орж, волейбол, дартсын тэмцээнийг зохион явууллаа. Нийт 19 албан хаагч гэр бүлийн хамт оролцлоо.<br><br>Мөн цахим орчинд Гэрлэлт, гэр бүлийн үүрэг хариуцлага, гэрлэлтийн үнэ цэн, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, видео шторк, постер бэлтгэн олон нийтэд түгээх, мэдлэгийг нэмэгдүүлэх тал дээр анхааран ажиллаж байна. | 70 | 70 |
| | 3 | Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах чиглэлээр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана. | 2020-2024 | ЗДТГ | 313.0 | 90 | Хүүхдийн зурсан зурганаас хүүхдийн гэр бүлийн гишүүддээ хандах харьцаа хандлага, гэр бүлийн дотоод уур амьсгал (тухайлбал зөрчил сөргөлдөөн) гэр бүлийн дотор хүүхдийн эзэлж буй байр суурийг тодорхойлох зорилготой “Гэр бүлийн хөрөг зурган судалгаа” хийсэн бөгөөд нийт хүүхдийн дийлэнх хувь буюу 62% нь сэтгэлийн зовиуртай, анхаарал халамж шаардалагатай, өөрийн байгаа байдалдаа тааламж муутай байдаг гэсэн дүгнэлт гарсан. Тухайн дүгнэлтэд суурьлан эцэг эх, асран хамгаалагч нарт нь сургалт зохион байгуулсан.<br><br>Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, сурагчдын хууль эрх зүйн | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдлэгийг дээшлүүлэх, зорилгоор Тарагт сумын ГХУСАЗСЗ-өөс "Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа" дэвжээ тэмцээнийг ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Тэмцээнд 78 сурагч оролцлоо.<br>Тарагт сумын ГХУСАЗСЗ болон Өвөрхангай аймгийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн газрын хамтын ажиллагааны хүрээнд ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчид болон иргэд албан хаагчдад зориулан “Сэтгэл зүйгээ удирдан танихуй”, “Эерэг хандлага төлөвшүүлэхүй” сэдэвт сэтгэлзүйн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад ЕБС-ийн 74 сурагч, 36 төрийн албан хаагч хамрагдлаа. | | |
| | 4 | Хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх ажлыг салбар дундын зохицуулалтаар хангаж, гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, гэр бүл салалтын эсрэг хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, хамтарсан багийн гишүүдийг чадваржуулан сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөөг орон нутгийн иргэдэд өгөх чадвартай болно. | 2020-2024 | ЗДТГ | - | 70 | Хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх ажлын хүрээнд “Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан Насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг гарган, дараах заалтуудыг цахим орчинд байрлуулан иргэдэд сурталчлан, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх уриалга гаргасан.<br>Насанд хүрээгүй хүнийг ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллуулах, мөн уртын гэрээгээр ажиллуулахыг хориглосон.<br>Оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх болон хууль тогтоомжоор хориглосон хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон.<br>Хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөг хэлбэрээр ашиглах, цалин хөлсийг шударга бусаар тооцож олгох, хүүхдийн нэрээр хууль бусаар үйл ажиллагаа явуулах зэрэг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг хүүхдээр эрхлүүлэхийг хориглосон. | 70 | 70 |
| Зорилт 2. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулан, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлнэ. | 1 | Багийн дарга нарын уялдаа холбоог сайжруулж, хүчирхийлэлд өртсөн гэр бүл хүүхдийн мэдээллийг төлбөртэйгээр дуудлага мэдээлэл худалдаж авах. | 2020-2024 | ЗДТГ | 0.025 | 70 | Багийн засаг дарга, цагдаагийн ажилтан, Насан туршийн суралцахуйн арга зүйч нартай хамтран мэдээллийн санд шинэчлэл хийлээ.<br>Зохион байгуулсан арга хэмжээ:<br>1.Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 2 өрхийн 3 хүүхдэд хувцас, ахуйн хэрэглээний бараагаар дэмжлэг үзүүлэв.<br>2.Гэр бүлийн хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй 15 хүүхдийг эрсдэлийн даатгалд хамруулав.<br>3.Их булаг багийн засаг дарга, НТСТ-ийн арга зүйчтэй хамтран Сургууль завсардсан хөгжлийн бэрштээлтэй хүүхдийн гэрээр очиж нөхцөл байдлын үнэлгээ хийж, гэрийн даалгавар өгч ажилласан.<br>Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүд гэмт хэрэгт холбогдож болзошгүй, хүчирхийлэлд өртөх магадлалтай, | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн асран хамгаалагч, төрөл садантай уулзалт хийн, зөвлөгөө өгч, эрсдэлээс хамгаалах хариу үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>Мөн 2024 оны байдлаар ХХХБ нь нийт 15 кейс дээр ажилласан ба үүнээс гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 6, хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой 4, бие махбодын хүчирхийллийн шинжтэй 3, сэтгэл санааны хүчирхийллийн шинжтэй 2 кейс дээр тус тус ажиллаж шийдвэрлэсэн байна. | | |
| | 2 | Төр, хувийн хэвшлийн байгууллагуудад “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлж, “Гэр бүлийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хүүхэд хамгааллын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | - | 90 | Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлж байна.<br>Таргат сумын ХХХБ-аас Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтыг \Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэн сурталчилан таниулах үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.<br>Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд ажилчдад хүүхдээ цэцэрлэг сургуулиас авахад зориулж өглөө оройд 30 мин чөлөө олгодог. Мөн хүүхэд өвдсөн тохиолдолд ажилтанд 10 хүртэл хоногийн цалинтай чөлөө, хүүхэд харах шаардлагатай үед 3 хүртэл хоногийн цалинтай чөлөө, 12-р ангиа төгсөж буй хүүхэдтэй ажилтанд ЭЕШ-нд орох, их сургуульд хүргэж өгөхөд нь тус тус цалинтай чөлөө олгох зохицуулалтыг хөдөлмөрийн дотоод журмандаа тусгаж өгч мөрдөн ажиллаж байна. Жил бүрийн 6-р сарын 1-ны өдөр байгууллагын албан хаагчдын хүүхдүүдэд дундын сангаасаа нийлж гарын бэлэг бэлтгэн хүргүүлдэг. Гэр бүлийн зөвлөлийн хүрээнд 1 удаа байгууллагын албан хаагчдын дунд арга хэмжээг зохион байгуулсан. | 90 | 90 |
| Зорилт 3. Залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн орчин нөхцөлийг бүрдүүлж, тэдний оролцоог хангах олон талт арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн идэвхтэй гишүүн болгоход дэмжлэг үзүүлнэ. | 1 | Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хөдөөгийн залуучуудыг хөгжүүлэх, эрүүл амьдралын зөв хэв маягт суралцах явуулын үйлчилгээг нэвтрүүлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 0,5 | 30 | Монголын залуучуудын холбооны дунд ба урт хугацааны стратегийн хөтөлбөрийг таниулан сурталчлах, бүс нутагт ажиллаж амьдарч буй залуучуудын тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг эрэлхийлж нийгмийн оролцоогоо олон талд хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготойгоор "ОРОЛЦ, МАНЛАЙЛ, НӨЛӨӨЛ" уриан дор бүтцийн шатны салбар байгууллагын 7000 орчим залуучуудыг хамруулах уг чуулганд Таргат сумын залуучуудын төлөөлөл болсон 6 залуу оролцлоо. | 30 | 30 |
| | 2 | Залуучуудын хөгжлийн бүлэг, клубын үйл ажиллагааг болон | 2020-2024 | ЗДТГ | 2.0 | 90 | 2024 оны 01 сарын 18-ны өдөр Таргат сумын Залуучуудын зөвлөлийг ЕБС-ийнНийгмийн ажилтан З.Нямбатаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгууллаа. Залуучуудын | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сайн дурын ажил, санал санаачилгыг бүх талаар дэмжинэ | | | | | зөвлөлөөс залуучуудын хөгжил, оролцоог дэмжих ажлын хүрээнд:<br>1. 2024 оны 4 дүгээр сарын 18-нд Өвөрхангай аймгийн Тарагт сумын ЕБС-ын 6-12-р ангийн сурагчдын төлөөлөл болох нийт 60 сурагчийг хамруулан "Mini Youth Power Taragt" байгальд ээлтэй залуусын чуулга уулзалт тус сургууль дээр амжилттай зохион байгуулагдлаа. Чуулга уулзалтаар өсвөр үе, залуучуудад байгаль хамгаалах үндэсний өв, соёлоо сурталчлах, хүрээлэн буй орчноо хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, экологийн боловсрол олгох, зөв харилцаа хандлагийг үе тэнгийнхэндээ уриалах зорилгоор үзэл бодлоо илэрхийлж уриалга гарган тунхаглалаа.<br>2. 2024 оны 01 сарын 13, 14-ны өдөр сумын залуучуудын дунд волейбол, шатар, дартс, шагайн харваа, ширээний теннис гэсэн спортын 5 төрөлт тэмцээнийг зохион байгууллаа. Тус тэмцээнд нийт 90 гаруй залуучууд оролцлоо. | | |
| | 3 | Тарагт суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудыг нэгдсэн байраар хангана. | 2020-2024 | ЗДТГ | | 0 | Хийгдээгүй болно. | 0 | 0 |
| Зорилт 4. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тасралтгүй хөгжүүлэх, тэдний эрэлт хэрэгцээнд суурилсан хөгжил оролцоог хангасан салбар дундын зохицуулалт хийж, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ. | 1 | Ахмадын өргөө шинээр барьж, үйл ажиллагааг тогтмолжуулна | 2020-2024 | ЗДТГ | 3,5 | 50 | Соёлын төвийн музейн барилгын халаалт, дулаан, гэрэл цахилгааныг шийдвэрлэн Ахмадын өргөө болгосон. Ахмадуудын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Ахмадын холбооны даргыг сар бүр 100000 төгрөгөөр урамшуулж, зохион байгуулж буй үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна. Ахмад настнууд ахмадын өргөөндөө өдөр бүр уулзалт зохион байгуулж цагийг зөв зохистой үр бүтээлтэй өнгөрүүлж дасгал хөдөлгөөнөө хийж байна.<br>Ахмадуудын дунд Сар шинийн баярын золголт, 9-н ээж алдаршуулах үйл ажиллагаа, Ач нэхээгүй тус аян, анхан шатны спортын бага наадам, ахмадын спортын бага наадам, Эх үрсийн баярын арга хэмжээг тус тус зохион байгуулан нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлсэн. | 50 | 50 |
| Дундаж үнэлгээ | | | | | | | | 68.2% | 66 |
| **1.6.ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ** | | | | | | | | | |
| Зорилт 1. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангаж, | 1 | Орон нутгийн нөөц боломжид тулгуурлан шинээр бий болох ажлын байрыг | 2020-2024 | ЗДТГ | 5,0 | 70 | Амралт сувилалд нийт Хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан 75 иргэн амралт сувилалын хөнгөлөлт эдэлсэн. | 70 | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ | | төлөвлөн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулан, ажилд зуучлах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ. | | | | | 2024 оны 8 сард малжуулах төсөлд 8 сая төгрөгийн зээлд 3 иргэн хамрагдан малаа худалдаж авсан. Хөдөлмөр эрхлэлтйин дэмжих сангийн иргэний зээлд 1 иргэн 5 сая төгрөгийн санхүүжилт авч сийлбэр болон фитнессийн бүс,гутал зэргийг хийж борлуулж байна.<br>Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйлчилгээнд 2 ахмадыг хамруулж тус бүр 1.200.000 төгрөгийг олгосон. Жил бүр төсөл хөтөлбөрт болон түр ажлын байруудад ажилгүй иргэдийг хамруулаад байна.<br>2024 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүдийг хамруулсан түр ажил буюу нийтийг хамарсан ажилд Тарагт сум үүсгэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой 2024 оны 7-р сарын 26,27 ны өдрүүдэд болохтой холбоотойгоор нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт үйлчилгээний ажлыг сумын төвийн айл өрхүүдийн хашааг будаж,хээ тавьсан ажилгүй байгаа зорилтот бүлгийн 10 иргэнийг хамруулсан.<br>Сэг зэм устгалын ажилд 5 багт Засаг даргын Тамгын газраас 7 албан хаагч, орон нутгаас зорилтот бүлгийн 10 хүн ажиллаж нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.<br>Сэг зэм цуглуулах тээврийн хэрэгсэлд 5 ачааны машин, булшлах тээвэрт 1 ковш, нүх ухах 1 экскаватор, ачааны машин 7 нийт машин, техник ажилласан.<br>Сэг зэм устгалын ажлын явц<br>Багийн Засаг дарга нар сэг цуглуулах ажлын маршрутыг гарган, сумын төвийн Хүрэмт , Арвайн тал Туяа Их булаг , Алтан тал багууд хамтран сэг зэм устгалын арга хэмжээг зохион байгуулав. Нийт бод 58, бог 824 бог малын сэг зэм хог хаягдлыг цуглуулж цэвэрлэсэн байна. Тус сум нь төв зам дагуу дайран өнгөрдөг тул зам дагуу хаясан бусад сумдын сэг зэм их байсан.<br>Ажлын явцад ажиллаж байгаа иргэдийн халдвар хамгааллын дэглэм мөрдөж маск бээлий тогтмол ашиглах солих, гараа ариутгах зэрэг санамж зааварчилгаа өгч ажилласан.<br>Гар аргаар ачих зөөх боломжгүй малын сэг зэмийг ковш ашиглаж ачиж, түрж булсан.<br>Тарагт сумын Үржлийн булгаас доош уруудан нуур хүртэл, сумын төвийн баруун зүүн жалга мөн далангуудыг цэвэрлэсэн.Нийт 2069 га голын 2 талаар цэвэрлэгээ хийж, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийтийн хогийн цэгийн хог, гол нуурын эрэг дагуух хогийг цэвэрлэх зориулалтын хогийн цэг дээр хаях, ил гарсан хогийг карерт булж байгаль орчны бохирдол, элдэв төрлийн өвчин эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлж хогийн цэг дээр булах зорилгоор нийтийг хамарсан ажил зохион байгуулж сумын ажилгүй 14 иргэнийг хамруулан 10 хоногийн хугацаанд тухайн ажлыг зохион байгууллаа. Нийтийг хамарсан ажил 2024.05.1-с 2024.05.15-ны хооронд ажлын өдрүүдэд зохион байгуулсан. Эдгээр иргэдийг түр хугацаанд ажлын байраар хангаж, нийтийн хогийн цэгийн хог, гол нуурын эрэг дагуух хогийг цэвэрлэх зориулалтын хогийн цэг дээр хаях, ил гарсан хогийг карерт булах, ажлыг чанартай сайн хийж гүйцэтгэсэн. Нийтийг хамарсан 3 ажил зохион байгуулж 30 иргэнийг өдрийн 40.000 төгрөгөөр ямар нэгэн суутгалгүй цалинг олгосон. Нийт 10 иргэн шинээр ажлын байранд зуучлагдсан. Нийтийг хамарсан түр ажлын байранд 50 иргэнийг цалинтай ажиллуулсан. Наадмын талбайн хайс будах ажилд 3 иргэн ажилласан. | | |
| | 2 | Харьцангуй бага хэрэглээтэй, дунджаас доогуур түвшний орлоготой өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн иргэнийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2020-2024 | ЗДТГ | | 50 | 2023 оны жилийн эцсийн байдлаар Тарагт сумын хэмжээнд нийт 23 өрх хүнсний талонд хамрагдаж байсан. 2024 оны 1 сард АДЗ-н хурлаар хэлэлзэн 10 өрхийг Амьжиргааны түвшин нөхцөл байдлын харгалзан үзэж ХЭБ-с түтгэлзүүлсэн. 2 өрх өөрийн хүсэлтээр ХЭБ авахаас татгалзсан байна.1 өрх шилжин суурьшсан.<br>Сумын иргэдээс өрхийн амьжиргааны түвшин тогтоолгох хүсэлт гаргасан иргэдийг өрхийн судалгаанд хамруулсан. Хөдөлмөр эрхлэлтийн зуучлалын албанд бүртгүүлж мэргэжил эзэмшүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.<br>Харьцангуй бага хэрэглээтэй дундажаас доогуур орлоготой өрхөөс судалгаа авах ажлыг зохион байгуулж 2024 оны 06 дугаар сард Өрхийн жагсаалтыг багийн Засаг дарга нартай тулгаж Арвайхээрт оршин суудаг 3 өрхийг аймгийн харъяаллаар нь өрхийг тус тус шилжүүлж, хаягтаа оршин суудаггүй албан ёсоор шилжсэн өрхүүдийг хасч эцсийн байдлаар нийт 6 өрхийн зураглалыг программд оруулсан. | 50 | 50 |
| | 3 | Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн зээл, төсөл, хөтөлбөрт хамруулан хүн амын | 2020-2024 | ЗДТГ | | 50 | Сумын ажил хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудын судалгааг гаргаж хөдөлмөр эрхлэлийн албанд бүртгэж зуучлах ажлыг зохион байгуулж байна. | 50 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ | | | | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт Ахмад мэргэжилтэний зөвлөн туслах үйлчилгээнд 2 ахмад хамрагдан тус бүр 1.200.000 төгрөгний цалин авсан.<br>Нэг гэр бүлийн 2 хөгжлийн бэрхшээлтэй хүнд 5 сая төгрөгний санхүүжилт олгож, хүлэмж, 1 тонныг ус нөөцлөх сав худалдан авсан. Хавраас хүлэмжээ байршуулан үйл ажиллагаагаа эхлэн хүнсний ногоо тариалж, сумын дэлгүүрт болонг аймагт худалдан борлуулсан. | | |
| | 4 | Цөөн малтай, мал маллах сонирхолтой малчин бус өрх болон залуучуудыг төсөл хөтөлбөрт хамруулах. | 2020-2024 | ЗДТГ | | 90 | Залуу малчин өрх нэмэгдсэн байна. Цөөн малтай, мал маллах сонирхолтой 200-с доош толгой малтай 3 гэр бүлийг төсөлд хамруулсан. Уг төсөлд өрх тус бүрт 8 сая төгрөгийн үнэ бүхий бог мал олгож, 3 жилийн хугацаанд хүүгүйгээр эргүүлэн төлөх нөхцөлтэй олгов. Нийт 24 сая төгрөгний мал худалдан авч өгсөн.<br>Нутаг дэвсгэрээр нь авч үзвэл Их булгаас 3 малчин 3 малчин тус хөтөлбөрт хамрагдсан. | 100 | 100 |
| Зорилт 2. Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 1 | Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн өрхүүдийг оновчтой тодорхойлно. | 2020-2024 | ЗДТГ | | 100 | Өрхийн мэдээллийн санд бүртгэлгүй өрхийн судалгаанд хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг судалгаанд хамруулж ажилласан.<br>Улсын хэмжээнд 2023 оны 5 сар явагдсан Амьжиргааны түвшин тогтоох судалгаанд нийт 25 өрхийг хамруулсан. Улсын хэмжээнд 2024 оны 5 сар явагдсан Амьжиргааны түвшин тогтоох судалгаанд нийт 6 өрхийг хамруулан ажиллаж байна. | 100 | 100 |
| | 2 | Зорилтот бүлгийн өрхүүдийн дунд бүлэг, хоршоо байгуулан, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр дэмжин ажиллана | 2020-2024 | ЗДТГ | | 70 | Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээ болон бусад хэлбэрээр тусламж дэмжлэгт хамруулж ажилгүй байгаа иргэдэд ажлын байраар хангагдах боломжийг судлан дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж нийтийг хамарсан ажилд хамруулсан. Зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах чиглэлээр нийт 63 хүнд хүргэсэн. Үүнээс 2 хоршоо хүнсний ногоо тариалж, өрхийн орлогоо нэмэгдүүлж байна. | 70 | 70 |
| | 3 | Нийгмийн халамжид хамрагдахад шаардагддаг материалыг цахимаар хүлээн авч, иргэдэд шуурхай үйлчилнэ | 2020-2024 | ЗДТГ | | 100 | Иргэд нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар авах боломжоор хангаж иргэд хүссэн газраасаа халамжийн үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Тарагт сумын албан ёсны цахим хаяг болон 3 группэд халамжийн үйлчилгээтэй мэдээллийг тухай бүрт нь оруулан иргэдэд мэдээлэл хүргэж байна. Тарагт сумын 6 багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж, хөдөө алслагдсан малчдад халамжийн цахим үйлчилгээнд цахимаар хэрхэн авах тухай мэдээлэл болон холбогдох гарын авлага танилцуулгыг хүргэн | 100 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллаж байна. Эрсдэлгүй өвөрхангай гар утасны апплекэйшийг нийт 100 иргэний гар утсанд суулгаж өгсөн.Аж ахуй нэгж байгууллагууд,иргэд, малчидад сурчилан таниулсан.Аюул эрсдлийг бууруулах зорилгоор Эрсдэлгүй өвөрхангай аппад нийт 4 иргэн мэдээлэл оруулсан холбогдох хүмүүст нь хэлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч байна.<br>ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗОРИЛТОТ ЖИЛ - 2024<br>Арга хэмжээ Тарагт суманд 4-р сарын 18-нд Арвайхээр сумын хурдан цэгийн албан хаагчид ирж сургалт, өдөрлөг зохион байгуулж тус арга хэмжээнд ЭРДЭЛГҮЙ ӨВӨРХАНГАЙ АПП иргэдэд суртчилан таниулж 20 иргэний гар утсанд суулгаж 50 ширхэг тараах материал тараасан. | | |
| | 4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог сайжруулна | 2020-2024 | ЗДТГ | | 90 | Сумын хэмжээнд байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхэд байна. Багийн эмч нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргаж, гэрээр айлчлан гэрийн асаргаа, эмчилгээг хийж, асран хамгаалагч нар асаргаа, сувилгааны талаар сургалт мэдээлэл хийж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдэд ном, тоглоомын багцаар үйлчилж, гэрээр нь боловсрол олгож байна. 2024 онд хөгжлийн бэрхшээлтэй өндөр настан, хүүхэд, хөдөлмөрийн насны давхардсан тоогоор нийт 60 гаруй иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн Аймгийн МСҮТ-д суралцаж байна. Нийгмийн халамжийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс үзүүлж буй тэтгэвэр,тэтгэмж хөнгөлөлт,тусламж дэмжлэг, арга хэмжээ болон тэтгэмжийн төрлүүд, цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах зорилгоор нийт 10 иргэнд мэдээлэл хүргэн ажиллаж байна. | 90 | 90 |
| Зорилт 3. Нийгмийн даатгалын мэдээллийг бүрэн цахимжуулан, иргэд даатгуулагчдад үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, | 1 | Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сан бүрдүүлж, архивын цахим лавлагааны үйлчилгээг жигдрүүлж, иргэд даатгуулагчдад шуурхай үйлчилгээ үзүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | | 100 | Нийгмийн даатгалын нийт 34 нэр төрлийн үйлчилгээний 70 гаруй хувь цахимжсан. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой лавлагаа, мэдээлэл тодорхойлолтыг цахимаар (ТҮЦ машинаар, www.portal.ndaatgal.mn цахим систем ашиглаж, гар утасны аппликейшн) авч байна. Энэ онд E-Mongolia-аас нийт 650 даатгуулагч иргэн нийгмийн даатгалын үйлчилгээг авсан байна.<br>2006 оноос хойших нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолтыг "Нийгмийн даатгалын шимтгэл | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана. | | | | | | | төлөлтийн тодорхойлолт" программыг ашиглаж дахин давтагдашгүй тоон өгөгдөл бүхий QR кодтой гаргаж тэтгэвэр, тэтгэмж олгоход ашиглаж байна. Дээрх лавлагааг нийт 2021-2024 оны байдлаар нийт 740 иргэнд гаргаж үйлчилсэн байна. Сайн дурын даатгалын гэрээ сунгах болон шимтгэлийн орлогыг цахимаар төлж хэвшлээ. Нийгмийн даатгалын сангийн нийт гүйлгээний 40 гаруй хувийг цахимаар төлсөн.<br>Ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайланг 100 хувь цахимаар авч хэвшсэн. Сумын хэмжээнд нийт 551 тэтгэвэр авагч байгаа бөгөөд нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэгт хавсаргасан материалыг сканердаж мэдээллийн бааз үүсгэн 100 хувь цахимжуулсан. | | |
| | 2 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаан биелүүлж, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ | 2020-2024 | ЗДТГ | | 100 | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жил бүр 98,0-100,0 хувиар давуулан биелүүлж байна.<br>Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд сум орон нутгийн удирдлага, багийн Засаг дарга нартай хамтран сургалт сурталчилгааг зохион байгуулж, сум, багуудын иргэдийн нийтийн хурал, малчдын зөвлөгөөн, явуулын үйлчилгээ, бусад төрийн байгууллагуудтай хамтран "Хууль сурталчлах өдөрлөг", "Нээлттэй өдөрлөг" ,малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2021-2024 онуудад нийт 85 удаагийн сургалт, сурталчилгааг давхардсан тоогоор 1892 иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг сурталчлан таниулав.<br>Зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн видео бичлэг, лайв, зурган мэдээлэл, постер бэлтгэн цахим орчинд байршуулснаар 2021-2024 онуудад нийт 42 удаагийн цахим орчны мэдээллээс давхардсан тоогоор 9675 удаагийн хандалт авсан байна.<br>Дээрх сургалт сурталчилгааны үр дүнд сумын хэмжээнд нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хувиараа хөдөлмөр эрхлэгч 68, малчин 450 хамрагдсан нь нийт даатгуулагчийн 28 хувийг эзэлж байна. | 100 | 100 |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | | **80%** | 80 |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ** | | | | | | | | | |
| **2.1.Эдийн засаг** | | | | | | | | | |
| Зорилт 1. Сумын эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, худалдаа, | 1 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үйлдвэр, худалдаа, үйлчилгээний бизнесийн таатай | 2020-2024 | ЗДТГ | 0,4 | 30 | Суманд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн судалгааг сар бүр гарган хөдөө аж ахуй газарт хүргүүлэн ажилласан. Үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Өвөрхангайд үйлдвэрлэв төвд бүтээгдэхүүнүүдийг тавьж сурталчилаад байна. Мөн | 30 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ. | | орчныг бүрдүүлж, түүхий эдийн нөөцөд тулгуурлан бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог хөгжүүлнэ. | | | | | аймгийн ӨВ-Түшлэл 2022 үзэсгэлэн худалдаанд сумын үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэн оролцуулсан.<br>ӨВ-Түншлэл 2023 үзэсгэлэн худалдаанд сумын үйлдвэрлэл эрхлэгчид болон хоршоонд лангууны түрээсэнд 80000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн оролцуулсан. Тус үзэсгэлэнд 4 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 1,3 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.<br>Өв- Түншлэл 2024 үзэсгэлэн худалдаанд сумын үйлдвэрлэл эрхлэгчид болон хоршоонд лангууны түрээсэнд 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн оролцуулсан. Тус үзэсгэлэнд төмс хүнсний ногоо болон сур суран эдлэлийн бүтээгдэхүүнээр оролцож 2,5 сая төгрөгийн борлуулалт хийж . Хос арвай түрүү шилдэг оролцогч, Т.Чимэдгочоо шинэ бүтээгдэхүүнээр шалгарсан байна. | | |
| | 2 | Бүх төрлийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж хөгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 112,0 | 30 | ИТХ-ын 2024 оны 04 сарын 24 ны өдрийн 18/04 дүгээр тогтоолоор Төсөл сонгон шалгаруулах тов батлуулан 2024 оны 05 сарын 27 өдрөөс 1 сарын хугацаанд Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох зарыг байршуулсан болович нэг ч төсөл орж ирээгүй. | 30 | 30 |
| | 3 | Талх, нарийн боовны цехийн үйл ажиллагааг өргөжүүлэх. | 2020-2024 | ЗДТГ | | 0 | хэрэгжээгүй. | 0 | 0 |
| **2.2.Санхүү, төсөв** | | | | | | | | | |
| Зорилт 1. Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана | 1 | Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавина. | 2020-2024 | ЗДТГ | | 100 | Бүх төсөвт байгууллага Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй 100 хувь холбогдсоноор, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавигдаж байна. Цалингийн нэгдсэн системтэй холбогдсоноор НДШ, ХАОАТ тайланг програмаас шууд татаж гаргадаг болсон. Цалингийн мэдээллийн системээс шууд төрийн албан хаагчийн мэйл хаягруу цалингийн мэдээллийг илгээн хувь хүний нууцийг хангаж ажиллаж байна.<br>Төсвийн бүх байгууллагууд Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлыг системээр тавигдана. Цалингийн нэгдсэн системээс цахимаар цалингийн гүйлгээг амжилттай илгээж байгаа. нэгдсэн | 100 | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>системээр 7 төсөвт байгууллагын давхардсан тоогоор 130 албан хаагчийн 697,997.3 мянган төгрөгний цалин, урамшуулал, 83,077.1 мянган төгрөгний ндшимтгэлийн гүйлгээг дамжуулан олгосон байна. Гарт олгох цалин, ндш, хаоат татварын гүйлгээг заавал Цалингийн нэгдсэн системээр дамжуулан олгож байгаа. Хуулийн дагуу урьдчилгаа цалин, 2 дугаар хагасын цалин гэж 2 хуваан олгож байгаа. Дотоод хяналтын ажлын хэсэг хяналт шалгалт хийн, гарсан асуудалд зөвлөгөө өгөн ажиллаж байна.</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>2</td><td>Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллана</td><td>2020-2024</td><td>ЗДТГ</td><td></td><td>100</td><td>Төсвийн байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас улирал бүр хяналт, шалгалтыг хийж ажилласан. Мэдээ байршуулалт 2022 онд 96,8 хувь, 2023 онд 98,1 хувь, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 98,1 хувьтай байна. Тайлант онд шилэн дансанд хийгдсэн хяналт шалгалтаар Туяа багийн ЕБСургууль, Соёлын төв 2-р улирлын тайлан илгэгээгүй, ИТхурал 975,000 төгрөг, ЗДТГ 30,000,000 төгрөгний санхүүжилтыг мэдээллээгүй, ЕБС аудитын дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээллээгүй зэрэг зөрчил илэрснийг нөхөж байршуулсан. Дотоод хяналтын нэгжээс улирал бүр шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөгөө өгч ажиллаж байна.<br><table><tr><td>Шилэн дансны эрх</td><td>2022 он</td><td>2023 он</td><td>2024 он</td></tr><tr><td>Бусад</td><td>387</td><td>441</td><td>422</td></tr><tr><td>Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт</td><td>256</td><td>173</td><td>223</td></tr><tr><td>Төсөв, гүйцэтгэл</td><td>337</td><td>439</td><td>435</td></tr><tr><td>Хугацаандаа оруулсан</td><td>949</td><td>1033</td><td>1050</td></tr><tr><td>Хугацаа хоцроосон</td><td>31</td><td>20</td><td>20</td></tr><tr><td>Мэдээлэл оруулаагүй</td><td>0</td><td>0</td><td>0</td></tr><tr><td>Бүгд</td><td>980</td><td>1053</td><td>1070</td></tr><tr><td>Хугацаа хоцролтын хувь</td><td>3,2</td><td>1,9</td><td>1,9</td></tr></table></td><td>100</td><td>100</td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td>3</td>
<td>Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулна.</td>
<td>2020-2024</td>
<td>ЗДТГ</td>
<td>0,1</td>
<td>70</td>
<td>Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 43 иргэнтэй холбогдож зээлийн төлөлтийг хийхийг ш хугацаа бүрэн дуусссан иргэдийн зээлийг шүүхийн байгууллагад шилжүүлсэн байна. Х төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг баталсан.
<table>
<tr><th>Он</th><th>Эхний үлдэгдэл</th><th>Эргэн төлөлт</th><th>Зээл олголт</th><th>ҮА зардал</th><th>Эцсийн үлдэгдэл</th></tr>
<tr><td>2021</td><td>50,583.3</td><td>67,507.3</td><td>90,000.0</td><td>4,041.4</td><td>24,049.2</td></tr>
<tr><td>2022</td><td>24,049.2</td><td>71,300.7</td><td>0</td><td>269.5</td><td>95,080.5</td></tr>
<tr><td>2023</td><td>95,080.5</td><td>88,013.4</td><td>112,000.0</td><td>947.6</td><td>70,146.3</td></tr>
<tr><td>2024</td><td>70,146.3</td><td>80,394.9</td><td>0</td><td>495.0</td><td>150,046.2</td></tr>
</table>
<table>
<tr><th rowspan="2">он</th><th rowspan="2">Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</th><th rowspan="2">Зээлийн үлдэгдэл</th><th colspan="4">Хугацаа хэтэрсэн зээл</th></tr>
<tr><th>Явцын хугацаа хэтрэлт</th><th>Гэрээний хугацаа бүрэн дууссан</th><th>Найдваргүй</th><th>Нийт</th></tr>
<tr><td>2021</td><td>24,049.2</td><td>216,199.1</td><td>30,207.9</td><td>23,729.9</td><td>260.0</td><td>54,197.8</td></tr>
<tr><td>2022</td><td>95,080.5</td><td>149,022.1</td><td>23,389.0</td><td>29,563.0</td><td>260.0</td><td>53212.0</td></tr>
<tr><td>2023</td><td>70,146.3</td><td>176,337.4</td><td>0</td><td>45,386.9</td><td>260.0</td><td>45,646.9</td></tr>
<tr><td>2024</td><td>150,046.2</td><td>96,151.2</td><td>0</td><td>19,480,3</td><td>260,0</td><td>19,740.3</td></tr>
</table>
</td>
<td>70</td>
<td>70</td>
</tr>
<tr>
<td></td>
<td>4</td>
<td>Цахим тендер шалгаруулалтыг нэмэгдүүлж, цахим системийн хөгжил, шинэчлэлийг ашиглана</td>
<td>2020-2024</td>
<td>ЗДТГ</td>
<td>-</td>
<td>100</td>
<td>Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан 197,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээг /www.tender.gov.mn/-д 100 хувь, 2022 онд 35.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа, 2023 онд 100,0 сая төгрөгийн 2 төсөл арга</td>
<td>100</td>
<td>100</td>
</tr>
</table>

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээг, 2024 онд 372,9 сая төгрөгний 4 төсөл арга хэмжээг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ийн шинэчлэлийг тухай бүрд ашиглаж, төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төлөвлөгөөнд тусгагдсан 9 төсөл арга хэмжээний тендерт шалгарсан аж ахуйн нэгжийн захиалагчтай байгуулсан 9 гэрээг удирдлагын системд байршуулсан байна. | | |
| | 5 | Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлнэ | 2020-2024 | ЗДТГ | 0,1 | 100 | 2022 онд ЕБС-ийн дотуур байр, Цэцэрлэгийн зөөлөн эдлэл 15,680,000 төгрөг, Сумын хэмжээний газар зүйн нэрийн тодруулга 12,000,000 төгрөг, Худаг гаргах, засварлах ажил 10,000,000 төгрөг<br>2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Туяа багийн ЕБС-ийн хайсан хашаа 18,000,000 төгрөг, Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хийгдсэн хайсан хашаа 15,453,000, Хогийн цэгийг цэгцлэх, хог преслэх машин авах 50,000,000 төгрөгний ажлуудад хяналт тавьж ажилласан.<br>2024 онд ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтээр санхүүжигдсэн Нуурын далангийн засварын ажил 30,000,000 төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Наадмын талбай барих ажил 150,000,000 төгрөгийн ажлуудад дотоод хяналт шалгалтын нэгжээс хяналт тавьсан. 2020-2023 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, тайлагналт, архивын материалын бүрдүүлэлтийг журмын дагуу бэлтгэсэн. 2023 онд Худалдан авах ажиллагааны газраас цахим системийн ашиглалт, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны нөөц бүрдүүлэлтийн байдалд хяналт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөгөөг өгч, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж өгсөн. | 100 | 100 |
| Зорилт 2. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ**.** | 1 | Татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, татварын багц хуулийн шинэчлэлийг таниулж, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг өөрчлөн, заавар, зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулна. | 2020-2024 | ЗДТГ | 0,2 | 70 | Татварын үйл ажиллагаа бүрэн цахимжиж тайлант хугацаанд татварын шинэчлэл, багц хуулиудыг сурталчлах хүрээнд багийн хурал байгууллагуудаар 5 удаагийн сургалтад 263 татвар төлөгчийг хамруулсан. Цахим татварын талаар аймгийн Татварын хэлтсийн сайтад байршуулсан мэдээллүүдийг сумын группэд тухай бүр шейрлэн иргэдэд хүргэж байна. Татвар төлөгчдөд тайлан ирүүлэх, татвар | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөхтэй холбоотой заавар, зөвлөгөөг утсаар болон биечлэн 174 татвар төлөгчдөд хүргэсэн. | | |
| | 2 | Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгон, татварын бааз суурийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 0,1 | 100 | Суманд үйл ажиллагаа явуулдаг хүнсний дэлгүүрүүдийг иргэнээр татвар төлдөг байсныг аж ахуй нэгжээр болгосон. Татварын хялбаршуулсан системд шилжсэнээр иргэн, аж ахуй нэгжийн татварын бүртгэл эрчимжиж, сумын 2024 оны төсөвт үйл ажиллагааны орлого 8,299,0 мянга төгрөгний орлого орсон байна. Татварын хялбаршуулсан тайлан илгээх хүсэлтээр аж ахуй нэгж, иргэний тайланг илгээж байна. Энэ онд шинээр байгуулагдсан 1 компани, 28 хоршоог татварт, 3 иргэнийг НӨАТ төлөгчөөр бүргэн татварын бааз суурийг нэмэгдүүлсэн. Суманд үйл ажиллагаа явуулдаг хүнсний дэлгүүрүүдийг иргэнээр татвар төлдөг байсныг аж ахуй нэгжээр болгож төлбөрийн баримтыг олгож байна. | 100 | 100 |
| Дундаж үнэлгээ | | | | | | | | 91.4% | 70 |
| **2.3 Уул, уурхай, ашигт малтмалын үйл ажиллагаа** | | | | | | | | | |
| | 1 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлагыг сайжруулж, ашиглалтыг хуулийн хүрээнд явуулна. | 2020-2024 | ЗДТГ | 0.1 | 70 | 2021 онд Өгөөмөр өргөө ХХК түгээл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 19,0 сая төгрөг, 2022 онд Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн авто замын шинэчлэл, их засварын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээг “Эйч Кэ Би Интернейшинл Холдинг” ХХК-2500,0 мянган төгрөг. | 70 | 50 |
| **2.4. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа үйлчилгээ** | | | | | | | | | |
| Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлэх бодлого баримталж, бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлж хөдөө | 1 | Цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэн, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна. | 2020-2024 | ЗДТГ | - | 70 | Цөм сүргийг ангилан ялгаж, цөм сүргийн хонь 175, ямаа 129 нийт 304 малыг бүртгэлжүүлсэн. Мэдээллийн санд шинэ 17 малчин өрхийн мэдээлэл оруулж шинэчлэлтийг бүрэн хийсэн. Энэ онд нийт 973 малчин өрхийн мэдээллийг шинэчилсэн. Шилжин ирсэн болон явсан малчны мэдээллийн Мал эмнэлгийн нэгж, болон тасгийн байцаагчаар дамжуулан шилжилт баталгаажуулалтыг хийлгэж байна. Улс, аймаг, сумын сайн малчин болж буй малчдын малыг даатгалд хамруулсан байх шаардлагыг тавьж бүрэн хамруулсан. Мөн малчид банкнаас зээл авахад малыг даатгалд хэсэгчлэн хамруулж байна. | 70 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| аж ахуйн тогтвортой хөгжлийг хангана. | 2 | Мал аж ахуйн түүхий эдэд түшиглэсэн арьс, шир, ноосыг уламжлалт технологи болон бага оврын тоног төхөөрөмж ашиглан боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг цех байгуулна. | 2020-2024 | ЗДТГ | 3,0 | 30 | Сарлаг эрдэнэ сүү хоршоо арьс элдэх тоног төхөөрөмж оруулж ирсэн. Байрны асуудал одоогоор шийдэгдээгүй байна. Хоршоо хөгжүүлэх сангаас 4 иргэнд нэхий элдэх, сур элдэх жижиг оврын төхөөрөмж авах зориулалтаар 17 сая төгрөгийн зээл олгосон. Үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 30 | 30 |
| | 3 | Газар тариалан бүхий нутаг, төв суурин газрууды түшиглэн өндөр ашиг шимтэй мах, сүүний, хосолмол үхрийн эрчимжсэн аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | | 30 | Зах зээл ба бэлчээрийн менежмент төслийн шугамаар 11 малчныг өндөр ашиг шимт малын аж ахуйд туршлага судлуулсан. Цаашид суманд хэрэгжиж буй хөнгөлөлттэй зээлд хамруулахаар ажиллаж байна. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх газар олголт төлөвлөгөөнд тусгагдан шийдвэрлэгдвэл үйл ажиллагаа эрхлэх иргэд бэлэн байгаа.<br>Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд Мах, сүүний чиглэлийн үхэр авахад 6 иргэнд 48,0 сая төгрөгийн зээл олгож, иргэдэд дэмжлэг үзүүлсэн. | 30 | 30 |
| | 4 | Сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг орон нутгаас бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулан, түүнийг газар, талбай, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үр ашигтай ажиллуулна. | 2020-2024 | ЗДТГ | 0,7 | 30 | 2024 онд Өвөлжөө, хаваржааны газартаа нийт 250 малчин өрх малын тэжээлийн ургамал тариалсан. ЗДТГ-аас 10 тонн ногоон тэжээлийн үрийн дэмжлэг 100% үнэгүй үзүүлсэн. Нэг өрхөд 40 кг овъёосны үр олгосноор малчид тэжээл тариалах арга зүйд суралцан, өвс тэжээлийн нөөцийнхөө тодорхой хувийг өөрсдийн хүчээр бэлдэж хэвшээд байна. Хүрэмтийн услалтийн системийн ашиглалтыг сайжруулчихвал Баянхосын тариалангийн талбайг 100 хувь ашиглан малын тэжээлийн тариалалт нэмэгдэх нөөц боломжтой байна. | 30 | 30 |
| | 5 | “Малын тоо толгойн албан татварын тухай” хуулийн дагуу татварын хувь хэмжээг тогтоохдоо бэлчээрийн даац, малын тоо толгойгоос чанарт шилжүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | | 70 | Сумын ИТХ-аас тогтоосон хувь хэмжээгээр малыг тоо толгойн албан татварыг хурааж байна. Энэ онд малын тоо толгойн албан татвар 83.193.0 мянган төгрөгний төлөвлөгөөтэй гүйцэтгэл 41.169.9 мянга төгрөг буюу эхний 10 сарын байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна. 2022-2023 оны малын тоо тлгойн албан татварын өртэй 412 малчинтай холбогдож 23.1 сая төгрөгний татварын өрийг барагдуулсан. | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |
| | 6 | Сүү боловсруулах цех байгуулж, малчид, иргэдийн сүү, цагаан идээ боловсруулж аймаг хотын зах зээлд гаргах идэвхийг дэмжиж ажиллана. | 2020-2024 | ЗДТГ | | 90 | Өрхийн үйлдвэрлэлээр сүү, цагаан идээ боловсруулан худалдаалдаг малчин өрхүүд жил бүр нэмэгдэж байна. Айраг худалдаалдаг 17 малчин, сүү цагаан идээ худалдаалдаг 21 малчин өрх байна. 2020-2023 онд 20 иргэнд 114 сая төгрөгийн зээл олгосон. Эдгээр иргэд сүү цагаан идээ худалдан борлуулж байна. | 90 | 30 |
| | 8 | Монгол улсад болон өөрийн аймагт үржүүлж байгаа ашиг шимт үүлдэрийн малын биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгаа хийж, шаардлага хангасан үүлдэр, омог, хэвшлийн малыг баталгаажуулан, мал үржлийн ажлыг үр дүнтэй зохион байгуулна. | 2020-2024 | ЗДТГ | | 50 | Манай аймагт Баянгол омгийн хонь, бараг үүлдрийн хонь, тээлийн улаан зэрэг бог малын үүлдэрлэг байдлыг үржүүлж байна. Малчдаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Нарийнтээлийн улаан ухна, Баянгол сумын Баянгол омгийн хуц үржүүлдэг иргэдийн холбогдох утас, хаягийг өгч холбон зуучилсан. 2024 онд малын гоц халдварт цэцэг өвчны дэгдэлт их байгаатай холбогдуулан малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулахыг аймгийн засаг даргын захирамжаар хориглосон тул гадны аймаг сумдаас цөм сүргийн мал үржилд худалдах ажил зохион байгуулаагүй бөгөөд өөрсдийн нөөц боломжид суурилж мал үржлийг технологит хугацаандаа бүрэн хийгдсэн. | 50 | 50 |
| | 10 | Суманд малын эмийн сан, мал эмнэлгийн байр барьж, байгуулах ажлыг дэмжин ажиллана. | 2020-2024 | ЗДТГ | | 30 | Дүүрэн арвин буян ХХК, Тарагт жирэм ХХК, Хүрэмт тэнүүн хангай ХХК , Хурдан хээр хоршоо, Довын хөндийн ХХК мал эмнэлэгийн нэгжүүдэд мал эмнэлэгийн үйл ажиллагаа явуулахад байраар хангаж ажиллаж байна. | 30 | 30 |
| | 11 | Бэлчээрийг бордох, олон наст ургамал тариалах, хашиж хамгаалах зэргээр бэлчээрийн ашиглалтын менежментийг сайжруулах, инженерийн хийцтэй худаг шинээр барих, засварлах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 50,8 | 90 | 2024 туяа багт 2 малчин хувийн хөрөнгөөр гүн өрмийн худаг шинээр гаргасан. Малын тоо толгойн албан татвараас туяа, алтан тал багт 2 худаг засварлахаар төлөвлөсөн боловч татварын бүрдүүлэлтээс шалтгаалан хугацаандаа хийгдээгүй. | 100 | 50 |
| | 12 | Түүхий эд хүлээн авах төвлөрсөн цэгтэй болох, хоёрдогч түүхий | 2020-2024 | ЗДТГ | 12,5 | 30 | Түүхий эд худалдан авах цэгтэй болсон. Сум хөгжүүлэх сангаас 1 иргэнд 5,0 сая төгрөгийн зээлийг олгосон. Сумын төвд хоёрдогч түүхий эд авах үйлчилгээ үзүүлэн ажиллаж | 30 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эд боловсруулах жижиг үйлдвэртэй болох. | | | | | байна. 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хог прэсслэх 30 тонны 10кв хүчин чадалтай машин авсан. | | |
| Зорилт 2. Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, шинэ нэр төрлийн таримлыг тариалах замаар импортын хэрэглээг бууруулна. | 1 | Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, тариаланчдыг үр, бордоо, техникийн дэмжлэгт хамруулан, дотоодын хэрэгцээний төмс, хүнсний ногооны 60 хувийг хангана. | 2020-2024 | ЗДТГ | 1,0 | 100 | 2024 онд Төмс 17 га-д, хүнсний ногоо 10,45 га-д хаврын тарилтаа технологийн дагуу 05-р сарын 05-наас 05-р сарын 20-ны хооронд хийв. Тариалангийн талбайн ашиглалтыг нэмэгдүүлж, талбай хувиарлалтыг төмс, хүнсний ногоо тариалах хүсэлтэй 2 ААН, 10 иргэнд талбайн хувиарлалт хийж хаврын тарилтыг хийж ажилласан.Төмс тариалах тариаланчдад стандартын шаардлага хангасан гарал үүсэл бүхий Гала сортын үр 5 тн-ыг захиалан тарилт хийсэн. ХХААЯ-наас 80 хувийн хямдралтай үрийн захиалгыг 2023 онд 104.000 төгрөгөнд, 2024 онд 169.0 Сумын Тамгын газраас шийдүүлэн тариаланчддаа тараан тариалалтыг бүрэн хийлгээд байна.<br>Ногоон тэжээл 65 га-аас 130 тн ургац, төмс 17 га-аас 163 тн ургац, хүнсний ногоо 10.45 га-т тариалалт хийж, 93 тн ургац хураан авсан. | 100 | 100 |
| | 2 | Атаршсан талбайг эргэлтэд оруулж, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэн, отор нүүдлийг багасгаж, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 3,0 | 30 | Малчин өрх бүрт өөрийн өмчилж авсан өвөлжөө, хаваржааныхаа 0.7 га газарт 0.1 га-с хэтрүүлэхгүйгээр бэлчээрийн малын тэжээлийн ургамлын үрийг сумын 6 багаас 250 малчин өрхийг хамруулан, нэг айлын 40 кг үрийн 100 хувийг буюу 10 тн үрийн дэмжлэгийг сумын ЗДТГазраас үзүүлэв. Тарилтын ажлыг 6 дугаар сарын 10-аас 07 дугаар сарын 05-ны хооронд зохион байгуулж, тарилтыг технологийн дагуу хийсэн. Нийт 50 тн ургац хураан авсан. Ургацын бланс өрх бүр харилцан адилгүй байна. | 30 | 30 |
| | 3 | Хүрэмтийн услалтын системийн засварын ажлыг хийнэ. | 2020-2024 | ЗДТГ | | 70 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу ЗДТГазрын өмчлөлийн услалтын системийг Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд Хиймэл нуурын даланг сэргээн босгох, шинэчлэх, засварлах шаардлагатай байгаа талаарх доорхи мэдээллийг бэлтгэж явуулсан. Үерийн улмаас нуурын далан сэтэрсэн. Услалтын системийн ашиглалт эвдэрсэн. Үүнийг 2024 онд Улсын төсвөөс 34.000.000 төгрөг, Галт-Үнэг ХХК нийгмийн хариуцлагийн хүрээнд өөрийн хөрөнгөөр сэтэрсэн даланг битүүлж нуурын усыг хуримтлуулснаар нуур дахин сэргэсэн, болович далангын доогуур усны шүүрэл явагдаж байгаа. | 70 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | Газар тариалан, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, төрөлжсөн зоорь, өвлийн хүлэмжийн аж ахуй, малын тэжээл зэргийн тариалалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч дэмжиж ажиллана | 2020-2024 | ЗДТГ | 40,0 | 100 | Гурван улиралын 4х8 хэмжээтэй 40 мкв хүлэмжийг ОУТХ-ийн санхүүжилтээр ЕБС-ийн хашаанд барьж, ашиглалтанд оруулан тарилтаа бүрэн хийсэн. Мөн 30 тн багтаамжтай зоорийг 10 сая төгрөгийн төслийн санхүүжилтээр хийж ашиглалтанд оруулаа. Сумын төвд нийтийн зориулалттай 40 тны багтаамжтай зоорь 2021 оноос ашиглаж байна. Зоорины хүрэлцээ хангамж 100 хувь шийдэгдсэн.<br>Аймгийн хөрөнгө оруулалтаар 4:6 хэмжээтэй зуны хүлэмж 2ш өгсөн. Сумын тариалан эрхлэгч 2 өрхөд гэрээ байгуулж өгсөн. Хоршоо хөгжүүлэх сангаас зуны хүлэмж барихаар 1 иргэн 7.0 сая төгрөгний зээл авсан. | 100 | 50 |
| | 5 | Өрхийн тариаланг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжөөр хангах. | 2020-2024 | ЗДТГ | 0,45 | 70 | 2023 онд хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтод жилийн хүрээнд өрхийн тариалан эрхлэгч өрхийн 3,1 га талбайг ЗДТГ аас үнэ төлбөргүй хагалж өгсөн. Жил бүр Хүрэмт усалгаатай тариалангийн талбайд тариалан эрхэлж байгаа иргэдэд хагалах, үрлэх техникийг зуучилж холбоо тогтоож өгч байна.<br>2024 онд өрхийн тариаланчдад 80 хувийн хөнгөлөлттэй үнээр 10 төрлийн хүнсний ногооны үрийг татан авч тариаландыг хямд үнээр хангасан. | 70 | 50 |
| Дундаж үнэлгээ | | | | | | | | 70 | 46 |
| **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | |
| **3.1.Цахим технологид суурилсан төрийн үйлчилгээ** | | | | | | | | | |
| Зорилго 1. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулж, төрийн үйлчилгээг хялбаршуулан, зардал хэмнэх тогтолцоонд шилжүүлэн, төрийн албан хаагчийн ажиллах орчинг сайжруулна. | 1 | Төрийн нэг цонхны үйлчилгээний төвийг тохижуулж, тоног төхөөрөмжөөр ханган, иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх операторын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх үйл ажиллагаа явуулна. | 2020-2024 | ЗДТГ | | 100 | Иргэдэд e-mongolia цахим системээр үйлчилгээг үзүүлж байна. Мөн сумын иргэдэд гар утсаараа цахимаар нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээг авах, лавлагаа мэдээлэл харах зэрэг үйлчилгээг сурталчилан ажиллаж байна. 2022 оны 3-4 дүгээр сард сумын Засаг дарга, Засаг даргын орлогчоор ахлуулсан 2 ажлын хэсэг гарч хөдөөгүүр айл өрхөөр орж холбогдох албан тушаалтнууд иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэн ажилласан.<br>Операторын эрхээ авсан. Тоон гарын үсгийн төхөөрөмжөө авч, иргэдэд үйлчилж байгаа. Үйлчилгээ үзүүлсэн нийт тоо 59.<br>Үйлчилгээний нэр — Нийт<br>Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт — 22<br>Иргэний үнэмлэхийн лавлагаа — 6 | 100 | 70 |

| | |
|---|---|
| Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа | 5 |
| Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар | 2 |
| Гэрлэсний бүртгэлийн лавлагаа | 2 |
| Регистрийн дугаарын лавлагаа | 1 |
| Мал тооллогын лавлагаа (иргэн) | 1 |
| Гэрлэсний бүртгэлийн лавлагаа (англи) | 1 |
| Багийн Засаг даргын оршин суугаа газрын хаягийн тодорхойлолт | 1 |
| Зээлийн мэдээлэл | 19 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг ашиглалтад оруулж, тавилга, хэрэгслээр хангах. | 2020-2024 | ЗДТГ | 21,0 | 70 | ЗДТГ-ын барилгыг Улсын комисс хүлээж аваагүй байна. Хандив болон өөрийн орлого, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 15 албан хаагчдад тавилга, хэрэгсэл, иргэний танхимыг тоног төхөөрөмжөөр хангав. Нийт 21 сая төгрөг | 90 | 90 |
| | 3 | Туяа багийн төвийг засварлах, төрийн байгууллагуудын албаны компьютер, техник хэрэгслийг шинэчлэх болон багийн Засаг дарга нарыг унаагаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 20,0 | 90 | Багийн Засаг дарга нарыг шинэ компьютерээр бүрэн хангасан. ЕБС-ын багш нар I pad-аар бүрэн хангагдсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон улсын төсвийн хөрөнгөөр ЗДТГ-ын санхүү албаны 3, Засаг даргын 1, Улсын бүртгэгчийн 1 нийт 5 компьютер, проекторын дэлгэц, чанга яригч, цагаан хоолой, өнгөт принтер 2, архивын баримтын автомат үдэгч, өсгөгч шинээр авсан. Туяа багийн төвийг ОНХСангийн хөрөнгөөр засварын ажлыг хийсэн. | 100 | 70 |
| **3.2.Эрх зүйн боловсролтой иргэн, хүний эрхийг хангасан нийгэм, авлигагүй засаглал** | | | | | | | | | |
| Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр | 1 | Цахим технологид суурилсан арга хэлбэрээр хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” | 2020-2024 | ЗДТГ | | 70 | “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн Засаг даргын 2021 оны А/23, 2022 оны А/114, 2023 оны А/125 дугаар захирамжаар тус тус аймгийн эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын нэгдсэн төлөвлөгөөний дагуу суманд төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| зохион байгуулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэн, тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | | | | Шинээр хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах, иргэдэд мэдээлэл түгээх, нээлттэй өдөрлөг зохион байгуулах зэрэг нийт 3 хэсгээс бүрдсэн 23 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ.<br><br>Сургалт, мэдээллийг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж, сумын төрийн албан хаагчдын хэмжээнд зохион байгуулсан нийт 23 удаагийн сургалтад давхардсан тоогоор иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 250 гаруй төлөөлөл хамрагдсан байна.<br><br>Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын мэдээ тайланг улирал тутам төсөвт байгууллагуудаас авч, дүн шинжилгээ хийж, хагас, бүтэн жил тутам Хууль эрх зүйн хэлтэст тайлагнан ажиллаж байна.<br><br>Сумын албан ёсны веб Taragt.gov.mn болон Тарагт сумын Засаг даргын Тамгын газар цахим хуудсаар хууль, эрх зүйн талаарх мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааг байршуулан олон нийтэд хүргэж байна. | | |
| | 2 | Авлигыг үл тэвчих үзэл хандлагын талаарх нийтлэл түүнийг цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулна. | 2020-2024 | ЗДТГ | | 70 | Авлигын эсрэг төлөвлөгөөг байгууллага бүр тухайн жилдээ гарган албан хаагчдаа авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн ИТХ-аас төрийн байгууллагын албан хаагч нарт авлигын эсрэг хуулийн талаар сургалт зохион байгуулж зөвлөгөө өгч ажилласан. Жил бүрийн 1-р сард хуулийн дагуу ХАСХОМэдүүлэг гаргадаг албан тушаалтнуудаас мэдүүлгийг авч цахим системд бүртгэн ажиллаж байна. Мөн төрийн байгууллагын дарга эрхлэгч нар гэрээт албан газруудтай болон шинээр томилогож буй албан хаагчидтай ашиг сонирхолын зөрчилгүй мэдэгдлийг тухай бүр мэдүүлж хэвшсэн. | 70 | 70 |
| | 3 | Хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалт, сурталчилгаа зохион байгуулж, авлигыг үл тэвчих үзэл хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр боловсролын байгууллагатай хамтран | 2020-2024 | ЗДТГ | | 70 | Авлигатай тэмцэх газраас явуулж буй цахим сурталчилгаа, видио контентуудыг татан сумын фэйсбүүк хуудсуудаар дамжуулан сурталчилан ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд дотуур байрын багш болон нийгмийн ажилтан, албан бус боловсролын багшаар дамжуулан мэдээлэл, сургалтуудыг тухай бүр өгч ажилласан. | 70 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| | 4 | Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, үр дүнг тооцон ашиг сонирхлын зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | | 100 | Жил бүр Авлигын эсрэг төлөвлөгөөг гарган сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Сумын хэмжээнд 12 албан хаагчаас хөрөнгө орлогын мэдүүлгийг авч хуулийн хугацаанд системд оруулж тайланг аймгийн хууль эрх зүйн хэлтэст хүргүүлдэг. Удирдах албан тушаалтнуудыг томилохдоо Авлигатай тэмцэх газраас ХАСУМ-ыг хянуулсны үндсэн дээр томилж байна. 2020-2024 онд нийт 17 албан хаагчийг хянуулсны үндсэн дээр албан тушаалд томилсон байна. | 100 | 100 |
| | 5 | Төрийн байгууллагуудад дотоод хяналтын нэгж ажиллуулан, төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | | 70 | Дотоод хяналтын нэгжийн бүрэлдэхүүнийг шинэчлэн сумын Засаг даргаар батлуулж тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг батлан төсөвт байгууллагуудын шилэн данс, төсөл хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлүүдийг хянах, төсөв хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавин ажилласан. Гарсан зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаа. | 70 | 70 |
| | 6 | Төрийн албан хаагчийг тогтвортой ажиллах баталгааг хангаж, чадахуйн зарчимд суурилж, төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, тэднийг дотоод, гадаадын сургалт, давтан сургалтад хамруулна. | 2020-2024 | ЗДТГ | | 90 | Төрийн албан хаагчдийн цалин нэмэгдэж сумын ИТХ-ын шийдвэрээр орон нутагт ажиллаж буй албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл урамшуулал олгодог болсноор сул орон тоо нөхөгдөж одоогоор 1 сул орон тоо үлдсэн байна. 1 орон тоонд тусгай шалгалтыг тогтмол зарлуулсаар байна. Дэс түшмэлийн 1 албан хаагчийг удирдлагын академийн алсын зайн сургалтанд хамруулсан. Албан хаагчдыг тогтвортой ажиллуулах зорилгоор хуучин 100 хүүхдийн дотуур байрыг Галт үнэг ХХК-ны хөрөнгөөр нийгмийн хариуцлагын хүрээнд 55 сая төгрөгөөр засварлаж, 10 албан хаагчийг амьдруулж байна. Мөн 5 гэр бүлийг орон нутагтаа суурьшуулан гэр бүлийн гишүүдийг нь ажлын байраар хангаж дэмжин ажилласан. | 100 | 50 |
| | 7 | Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн санг бүрдүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | - | 100 | Төрийн албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөө гаргах, тайлагнах журмыг танилцуулан сургалт зохион байгуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг төрийн захиргааны албан хаагчдаас авч хагас бүтэн жилээр дүгнэн ажиллав. 2023 оны 11 дүгээр сард Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 98 дугаар тушаалаар албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагнах журам шинэчлэгдэн батлагдсан. Үүний дагуу албан хаагчийг үнэлэхдээ үнэлгээний 70 хувь гүйцэтгэлийн үнэлгээгээр, 30 хувь нь тухайн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагаар үнэлэгдэж, байгууллагын албан хаагчдаас үнэлгээний хуудсаар санал авч дүгнэсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна. | 1 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг, гэрлэн дохиог нэмэгдүүлж, камерын хяналтын системийг хөгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 20,0 | 70 | Тарагт сум орон нутгийн 3,5 сая төгрөгийн санхүүжилтээр чиглэлийн 4, өндөр нягтаршилтай 1, нийт 5 камерыг суурилуулсан. 2020-2023 онд нийт 490 гэмт хэрэг, зөрчлийг теле-камерын тусламжтай илрүүлсэн байна.<br><br>2024 онд шинээр 50 сая төгрөгөөр 7 камертай гэрэлтүүлэг нэмж авсан. | 100 | 100 |
| | 2 | Нийгэмд түгээмэл буй архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бууруулах, таслан зогсоох олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 6,0 | 70 | Хамтарсан багийн хяналтад байдаг харилцааны зөрчилтэй, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэр бүлүүдийг аймгийн ХГБХХГ-ын Сэтгэл зүйчтэй холбон зуучилж хагас жилийн байдлаар 4 залуу гэр бүл сэтгэл зүйчээс зөвлөгөө мэдээлэл аван, үйлчилж байна.<br>Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг цахим сургалт, видео шторк, постер, гэр бүл рүү чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулж мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулж, иргэдэд урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг мэдээллэх, хүчирхийлэлгүй Амар тайван сум болох тухай уриалга гаргаж ажилласан. | 70 | 70 |
| **Батлан хамгаалах салбарт90** | | | | | | | | | **77,5** |
| Зорилт 1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөний дагуу сургалт, бэлтгэлийг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага олгоно. | 2020-2024 | ЗДТГ | - | 100 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн техник, хүний нөөцийг жил бүр шинэчлэн томилгоожуулж аймгийн Цэргийн штаб-т нууцын зэрэглэлтэйгээр хүргүүлдэг. Сургалт мэдээллийн ажил ирэх онд хийгдэхээр төлөвлөгдсөн. Сумдын ЗДТГ-ын дарга нарын бэлтгэл сургалт Булган аймагт зохион байгуулагдаж сургалтанд хамрагдсан. Сумын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалт 2 жил дутам зохион байгуулагдаж хамрагдсан. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг чадавхжуулж, зарим тоног төхөөрөмжөөр хангана. | 2020-2024 | ЗДТГ | 9,5 | 70 | Гамшгаас хамгаалах иж бзрэн дадлага сургуулийг Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж сумын онцгой комисс болон ерөнхий зориулалтын мэргэжилийн ангиудын гишүүдийг чадавхижуулсан. Тус арга хэмжээний хүрээнд мэргэжлийн ангийн гишүүдийн хувцас бусад холбогдох зардалд нийт 9.5 сая төгрөг зарцуулсан. | 70 | 70 |
| | 3 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цэрэг-эх оронч үзлийг төлөвлшүүлэх арга хэмжээг жил бүр зохион байгуулах. | 2020-2024 | ЗДТГ | - | 70 | Цэрэг татлагын нэгдүгээр ээлж 2024 оны 04 сарын 26-ны өдөр суманд зохион байгуулагдаж 120 залуу үзлэгт хамрагдсан. Эдгээр залуучуудад цэргийн албаны талаарх мэдлэг ойлголт өгөх зорилгоор сургалт зохион байгуулж гарын авлага материал тараасан. | 70 | 70 |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | | **83.3%** | 80 |
| **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ** | | | | | | | | | |
| Зорилт 2. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгалийн нөөцийг зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 1 | Хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэн аж ахуй нэгж, байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулж, эх үүсвэр дээр нь ангилж, хөдөө нутаг, гол усны хогийг цэвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2020-2024 | ЗДТГ | 5,0 | 70 | Жил бүрийн хавар намартаа нийт 4 удаа бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж сумын төв, ойролцоох голын дагуух хог, нуурны орчмын хогийг төрийн байгууллага, ард иргэдийн дайчлан зохион байгуулан ажиллаж байна. Энэ жил төрийн 6 байгууллага, 2 ААН, иргэд хог цэвэрлэгээнд оролцсон. Айл өрхүүдийг хог хаягдлыг сард 2 удаа ачих үйлчилгээг үзүүлж байна. Жолоочийн хөлсийг ЗДТГ-ын цалингийн сангаас шийдвэрлэж, хог хаягдал зөөх шатахууны зардал болон техникийн засвар үйлчилгээний зардлыг хог хаягдлын зардлаас шийдвэрлэв. Бүх нийтийн их цэвэрлэгээг 7 сарын 18-19 , 10 сарын 03, 04 өдрүүдэд Нийт 2 удаа зохион байгуулсан. ААН төсөвт байгууллагууд иргэд оролцож, гудамж талбай , Голын ай сав дагуу, болон зам дагуу төвлөрсөн хур хог хаягдлыг цэвэрлэж нийт 3100 га талбайд 310 тонн хог хаягдал цэвэрлэж төвлөрсөн хогын цэгт буулгаж устгасан байна. | 70 | 70 |
| | 2 | Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ | 2020-2024 | ЗДТГ | 80,0 | 100 | Өмнөх онд нийтийн хэрэгцээний талбайд 1160 ш , Хязгаарлагдмал хэрэгцээний талбайд 340ш мод тарьсан. Үүнээс Фонтны урд ногоон байгууламжийн талбайд Нөхөн тарилтаар 400 ширхэг бургас, Цэцэрлэгт хүрээлэнд 300 , Гэндэнгийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд 60 ш бургас, шинээр төв гудамжинд 400 ш хайлаас , хашаандаа мод тарья аян өрнүүлж 35 өрх 251 ш бургасны суулгац өгч нийт 1500 ширхэг мод тарьж хаврын тариалалтыг хийж гүйцэтгэсэн. 80 –аас дээш хувийн ургалттай байна. Намрын мод тарилтаар | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийтийн хэрэгцээний талбайд 3 төрлийн 5700 ш мод суулгасан. Нийт 7200 ш мод тарьж 2 га –аар ногоон байгууламжийг нэмэгдүүлээд байна. 2024 оны намар нийт мод тарьсан га талбайг усалгаа арчилгааг хуваарийн дагуу тогтмол хийж байна. Мөн энэ онд иргэн өөрийн эзэмшлийн 1 га тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, 3 төрлийн 1500 ширхэг мод бут шинээр тарьж байна. | | |
| | 3 | Аялал жуулчлалыг хөгжүүлж байгалийн болон түүх, соёлын дурсгалт газар, Хүрэмт халуун рашаан амралт сувилал зэрэг газруудыг аялал жуулчлалын маршрутад хамруулж дэмжин ажиллана. | 2020-2024 | ЗДТГ | 0.5 | 70 | Хүрэмт болон Өгөөмөр амралтанд амрагчдын тоо эрс нэмэгдсэн. Амрагчдын амрах байр, орчин нөхцөл сайжирсан. Амралт, рашаан сувиллыг сурталчилсан мэдээ мэдээллүүд цахим мэдээллийн хэрэгслээр цацагдаж иргэдэд мэдээлэл хүрч байна. Улсын чанартай төв зам дээр амралтын газрын хүрэх км заасан тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан. Сумын аялал жуулчлалын маршрут ,сумын брэнд бүтээгдэхүүн тодруулж Соёмбот уул, Морины их шүтээн, Аав хайрхан уул, Борхой бүргэдийн цохио, Хүрэмт халуун рашаан, Хүрэмт нуур гэсэн 6 чиглэлд маршрут гаргасан, Брэнд бүтээгдэхүүн Чимэдгочоогын сур суран эдлэл, Монгол мал маллах арга ухаан, Арвайн талын Л.Буяндүүрэнгийн Бод бог малын сархинаг гар урлал бүртгэгдсэн байна.<br><br>Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, төрийн албан хаагч , иргэдийг зорилгоор жил бүр мөсний баяр нэгдсэн арга хэмжээг сумандаа тогтмол зохион байгуулж байна. | 70 | 70 |
| Үнэлгээ | | | | | | | | | 72,1 |
| **НИЙТ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ** | | | | | | | | | |

-oOo-